



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТАМГЫН ГАЗАР**

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
ХӨТӨЛБӨРИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН  
ДҮН ШИНЖИЛГЭЭ**

Улаанбаатар хот  
2025 он

## АГУУЛГА

|                                                                  |    |
|------------------------------------------------------------------|----|
| ДҮН ШИНЖИЛГЭЭ.....                                               | 3  |
| 1.“Бүсчилсэн хөгжлийн бодлого”-ын хэрэгжилт .....                | 4  |
| 2.“Хүний хөгжлийн бодлого”-ын хэрэгжилт .....                    | 6  |
| 3.“Эдийн засгийн бодлого”-ын хэрэгжилт .....                     | 10 |
| 4.“Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого”-ын хэрэгжилт ..... | 12 |
| ДҮГНЭЛТ .....                                                    | 18 |
| САНАЛ .....                                                      | 19 |
| Хавсралт.....                                                    | 20 |

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2024-2028 ОНЫ  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН 2024 ОНЫ  
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ**

**Эрх зүйн үндэслэл:** “Алсын хараа-2050”, “Шинэ сэргэлтийн бодлого” Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогыг тогтвортой хэрэгжүүлж, хөгжлийн тулгамдсан асуудлыг цаг алдалгүй, хурдтай шийдвэрлэхийг зорин Монгол Улсын Их Хурлын 2024 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн 21 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг, 2 дугаар хавсралтаар “Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, зорилтот түвшин”-г тус тус баталж, 2024 оны 08 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн хэрэгжүүлсэн байна.

Монгол Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.9 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 117 дугаар зүйлийн 117.1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг баримталж, “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан”-д дүн шинжилгээ хийв.

**Зорилго:** “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан”-д дүн шинжилгээ хийж, цаашид анхаарах асуудлаар санал хүргүүлэхэд чиглэгдлээ.

**Арга зүй:** “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан”-д Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2.1, 6.2.2-т заасан аргачлалыг удирдлага болгов.

**Мэдээллийн эх сурвалж:** Дүн шинжилгээг дараах тайлан, мэдээлэлд үндэслэн гүйцэтгэлээ. Үүнд:

- Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”;
- “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн гүйцэтгэлийн тайлан”, “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан”;
- Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас Улсын Их Хурлын Тамгын газарт ирүүлсэн 2025.02.11-ний өдрийн 01/184 дугаар албан бичиг;
- Үндэсний статистикийн хорооны албан ёсны цахим хуудас зэрэг болно.

## НЭГ. ДҮН ШИНЖИЛГЭЭ

“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т тусгасан үндсэн 4 бодлогын хүрээнд нийт 16 чиглэл, 620 зорилт хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс “хэрэгжүүлж эхлэх хугацаа болоогүй” 30.5 хувь буюу 189 зорилтыг хасч, нийт 431 зорилтын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийсэн болно.

Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2024 оны сүүлийн хагас жилийн хэрэгжилтийг 34.0 хувь гэж үнэлж ирүүлсэн бол Улсын Их Хурлын Тамгын газраас хөтөлбөрийн зорилтыг хэрэгжилтийн дундаж 25.3 хувь буюу “хөтөлбөрийн хэрэгжилтийг үр дүнгүй” гэж үнэллээ.

Хүснэгт 1. Зорилтын хэрэгжилт, хувь

| Хэрэгжилт                                                        | Зорилт           | Хувь       |
|------------------------------------------------------------------|------------------|------------|
| - Үр дүнтэй буюу 100 хувийн хэрэгжилттэй                         | 4                | 0.6        |
| - Тодорхой үр дүнд хүрсэн буюу 70-100 хүртэл хувийн хэрэгжилттэй | 29               | 4.7        |
| - Эрчимжүүлэх шаардлагатай буюу 30-70 хүртэл хувийн хэрэгжилттэй | 232              | 37.4       |
| - Үр дүнгүй буюу 0-30 хүртэл хувийн хэрэгжилттэй                 | 166              | 26.8       |
| Хэрэгжүүлэх хугацаа болоогүй                                     | 189 <sup>1</sup> | 30.5       |
| <b>Нийт</b>                                                      | <b>620</b>       | <b>100</b> |

“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т тусгасан 431 зорилтоос “үр дүнтэй” хэрэгжсэн 4 зорилт, “тодорхой үр дүнд хүрсэн” 29 зорилт, “эрчимжүүлэх шаардлагатай” 232 зорилт байгаа бол “үр дүнгүй” 166 зорилт, “хэрэгжүүлэх хугацаа болоогүй” 189 зорилт байна. Тус хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлгээний ангиллаар, бодлого тус бүрээр харуулбал:

Хүснэгт 2.ЗГҮАХ-ийн 2024 оны хэрэгжилт, бодлогоор

| №    | Чиглэл                                    | Зорилгын тоо | Зорилтын тоо | УИХТГ-ын үнэлгээ  |    |    |    |     |     |     | дундаж хувь |
|------|-------------------------------------------|--------------|--------------|-------------------|----|----|----|-----|-----|-----|-------------|
|      |                                           |              |              | Хэрэгжилтийн хувь |    |    |    |     |     |     |             |
|      |                                           |              |              | 100               | 90 | 70 | 50 | 30  | 0   | ХБ  |             |
| 1    | Бүсчилсэн хөгжлийн бодлого                | 4            | 92           | 1                 | 1  | 2  | 5  | 27  | 26  | 30  | 22.4        |
| 2    | Хүний хөгжлийн бодлого                    | 4            | 152          | 2                 | 2  | 5  | 11 | 51  | 40  | 41  | 25.3        |
| 3    | Эдийн засгийн бодлого                     | 4            | 222          | 1                 | 5  | 9  | 27 | 54  | 67  | 59  | 25.5        |
| 4    | Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого | 4            | 154          | -                 | -  | 5  | 24 | 33  | 33  | 59  | 26.7        |
| Нийт |                                           | 16           | 620          | 4                 | 8  | 21 | 67 | 165 | 166 | 189 | 25.3        |

“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн нийт 431 зорилтоос 22.2 хувь буюу 138 зорилтын хэрэгжилт хангалтгүй байсан тул үнэлгээг бууруулан үнэлсэн бөгөөд бодлого тус бүрээр авч үзвэл:

- Бүсчилсэн хөгжлийн бодлогын 92 зорилтын 7 зорилт буюу 7.6 хувь;

<sup>1</sup> Хэрэгжүүлэх хугацаа болоогүй гэж тайлагнасан 189 зорилтыг үнэлгээнд оруулж тооцоогүй болно.

- Хүний хөгжлийн бодлогын 152 зорилтын 34 зорилт буюу 22.4 хувь;
- Эдийн засгийн бодлогын 222 зорилтын 48 зорилт буюу 21.6 хувь;
- Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлогын 154 зорилтын 49 зорилт буюу 31.8 хувийг тус тус эзэлж байна.

“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийхдээ нийт зорилтын 22.2 хувь буюу 138 зорилтын үнэлгээг бууруулсан үндэслэл нь:

- Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас тус хөтөлбөрийн хэрэгжилтийн дундаж үнэлгээг “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2.3-т заасан арга зүйг баримтлах байсан боловч хэрэгжилтийг 6.2.2-т зааснаар үнэлсэн нь 8.7 хувиар зөрүүтэй үнэлэгдэж байна;
- Зорилтын хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний үр дүнг тодорхой тайлагнаагүй, үр дүнд хүрээгүй тохиолдолд түүнд нөлөөлсөн шалтгаан нөхцөлийг тодорхой тайлагнаагүй;
- Зорилтын хэрэгжилтийг үнэлэхэд мэдээлэл хангалтгүй, хэрэгжилтийг дутуу тайлагнасан, үр дүнг бус үйл явцыг тайлагнасан, зорилтын агуулгаас зөрүүтэй тайлагнасан зэрэг нь үнэлгээг бууруулах шалтгаан болсон.

### 1.“Бүсчилсэн хөгжлийн бодлого”-ын хэрэгжилт

“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн “Бүсчилсэн хөгжлийн бодлого”-ын хүрээнд 4 чиглэл, 13 зорилго, 92 зорилтын хэрэгжилтийг Засгийн газраас 30 хувьтай гэж үнэлсэн бол Улсын Их Хурлын Тамгын газраас **22.4 хувь** буюу **“үр дүнгүй”** гэж үнэллээ.

Зураг 1.Тус бодлогын хүрээнд дүн шинжилгээ хийсэн нийт 92 зорилтын хэрэгжилт, хувиар



Хүснэгт 3.Тус бодлогын хүрээнд хэрэгжүүлсэн 4 чиглэлийн дундаж үнэлгээг хүснэгтээр үзүүлбэл:

| № | Чиглэл                                                             | Зорилгын тоо | Зорилтын тоо | УИХТГ-ын үнэлгээ  |    |    |    |    |   |    |             |
|---|--------------------------------------------------------------------|--------------|--------------|-------------------|----|----|----|----|---|----|-------------|
|   |                                                                    |              |              | Хэрэгжилтийн хувь |    |    |    |    |   |    | дундаж хувь |
|   |                                                                    |              |              | 100               | 90 | 70 | 50 | 30 | 0 | ХБ |             |
| 1 | 1.1.Улаанбаатар хот-“20 минутын хот” стандарт                      | 5            | 34           | 1                 | -  | 1  | 2  | 19 | 4 | 7  | 31.1        |
| 2 | 1.2.Бие даасан эдийн засаг бүхий улсын зэрэглэлтэй хот, дагуул хот | 2            | 11           | -                 | -  | -  | 1  | 2  | 2 | 5  | 18.3        |

|      |                             |    |    |   |   |   |   |    |    |    |      |
|------|-----------------------------|----|----|---|---|---|---|----|----|----|------|
| 3    | 1.3.Бүсийн төрөлжсөн хөгжил | 6  | 31 | - | - | - | 2 | 5  | 14 | 10 | 11.9 |
| 4    | 1.4.Орон нутгийн хөгжил     | 2  | 16 | - | 1 | 1 | - | 1  | 5  | 8  | 23.8 |
| Нийт |                             | 15 | 92 | 1 | 1 | 2 | 5 | 27 | 26 | 30 | 22.4 |

### **1.1 “Улаанбаатар хот - “20 минутын хот” стандарт” чиглэлийн хэрэгжилт:**

“Хот төлөвлөлт, засаглалын шинэчлэл”, “Эрчим хүчээр хангагдсан хот”, “Гэр хорооллын дахин төлөвлөлт, орон сууцжуулалт”, “Ногоон- ухаалаг хот”, “Олон төрөлт нийтийн тээвэр, авто зам” гэсэн 4 зорилго, 34 зорилтын хэрэгжилт дунджаар 31.1 хувь буюу “эрчимжүүлэх шаардлагатай” байна.

- “үр дүнтэй” буюу 100 хувийн хэрэгжилттэй 1 зорилт;
- “тодорхой үр дүнд хүрсэн” буюу 70-100 хүртэл хувийн хэрэгжилттэй 1 зорилт;
- “эрчимжүүлэх шаардлагатай” буюу 30-70 хүртэл хувийн хэрэгжилттэй 21 зорилт;
- “үр дүнгүй” буюу 0-30 хүртэл хувийн хэрэгжилттэй 4 зорилт;
- “хэрэгжүүлэх хугацаа болоогүй” 7 зорилт байна.

### **1.2 “Бие даасан эдийн засаг бүхий улсын зэрэглэлтэй хот, дагуул хот” чиглэлийн хэрэгжилт:**

“Улсын зэрэглэлтэй болон дагуул хотуудын дэд бүтэц”, “Улсын зэрэглэлтэй болон дагуул хотуудын хөгжил” гэсэн 2 зорилго, 11 зорилтын хэрэгжилт дунджаар 18.3 хувь буюу “үр дүнгүй” байна.

- “эрчимжүүлэх шаардлагатай” буюу 30-70 хүртэл хувийн хэрэгжилттэй 3 зорилт;
- “үр дүнгүй” буюу 0-30 хүртэл хувийн хэрэгжилттэй 3 зорилт;
- “хэрэгжүүлэх хугацаа болоогүй” 5 зорилт байна.

Хангайн бүсийг “Уламжлалт мал аж ахуйн төрөлжсөн бүс бөгөөд хот байгуулалтын дэд бүс”, Баруун бүсийг “Эрчим хүчний төрөлжсөн бүс бөгөөд байгалийн аялал жуулчлалын дэд бүс”, Хойд бүсийг “Байгалийн аялал жуулчлалын төрөлжсөн бүс бөгөөд аж үйлдвэрийн дэд бүс”, Говийн бүсийг “Аж үйлдвэрийн төрөлжсөн бүс бөгөөд ногоон эрчим хүчний дэд бүс”, Төвийн бүсийг “Хөдөө аж ахуйн төрөлжсөн бүс бөгөөд аж үйлдвэрийн дэд бүс”, Зүүн бүсийг “Түүхэн аялал жуулчлалын төрөлжсөн бүс бөгөөд эрчимжсэн хөдөө аж ахуйн дэд бүс” болгон тус тус төрөлжүүлэн хөгжүүлэх хүрээнд 6 зорилго, 31 зорилтын хэрэгжилт дунджаар 11.9 хувь буюу “үр дүнгүй” байна.

- “эрчимжүүлэх шаардлагатай” буюу 30-70 хүртэл хувийн хэрэгжилттэй 7 зорилт;
- “үр дүнгүй” буюу 0-30 хүртэл хувийн хэрэгжилттэй 14 зорилт;
- “хэрэгжүүлэх хугацаа болоогүй” 10 зорилт байна.

### **1.4 “Орон нутгийн хөгжил” чиглэлийн хэрэгжилт:**

“Шилжилт хөдөлгөөн”, “Орон нутгийн хөгжлийн нийтлэг зорилт” гэсэн 2 зорилго, 16 зорилт дунджаар 23.8 хувийн хэрэгжилттэй буюу “үр дүнгүй” байна.

- “тодорхой үр дүнд хүрсэн” буюу 70-100 хүртэл хувийн хэрэгжилттэй 2 зорилт;
- “эрчимжүүлэх шаардлагатай” буюу 30-70 хүртэл хувийн хэрэгжилттэй 1 зорилт;
- “үр дүнгүй” буюу 0-30 хүртэл хувийн хэрэгжилттэй 5 зорилт;
- “хэрэгжүүлэх хугацаа болоогүй” 8 зорилт байна.

Асуудал 1. Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ тухайн зорилтын дундаж үнэлгээг арифметик дунджаар тооцоолоогүй, аргачлалын

6.2.2-т заасан хувийг тусгасан нь алдаатай байна. Үнэлгээний зөрүүтэй байдлыг хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт 4. “Бүсчилсэн хөгжлийн бодлого”-ын 2024 оны хэрэгжилт, хувь

| №    | Чиглэл                                                              | ЗГХХГ-ын үнэлгээ |                      | УИХТГ-ын үнэлгээ, хувь |
|------|---------------------------------------------------------------------|------------------|----------------------|------------------------|
|      |                                                                     | Тайланд тусгасан | Дундаж үнэлгээ, хувь |                        |
| 1    | 1.1. Улаанбаатар хот-“20 минутын хот” стандарт                      | 30.0             | 25.7                 | 22.4                   |
| 2    | 1.2. Бие даасан эдийн засаг бүхий улсын зэрэглэлтэй хот, дагуул хот | 30.0             | 35.7                 | 25.3                   |
| 3    | 1.3. Бүсийн төрөлжсөн хөгжил                                        | 30.0             | 33.8                 | 25.5                   |
| 4    | 1.4. Орон нутгийн хөгжил                                            | 30.0             | 39.8                 | 26.7                   |
| Нийт |                                                                     | 30.0             | 34.6                 | 25.3                   |

Асуудал 2. “Бүсчилсэн хөгжлийн бодлого”-ын үр дүнд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшнийг Улсын Их Хурлын 2024 оны 64 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-ын 02 дугаар хавсралтад заасан “хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин”-тэй нийцүүлэн боловсруулаагүй байна.

Асуудал 3. Монгол Улсын Их Хурлын 2024 оны 64 дүгээр тогтоолын 02 дугаар хавсралтаар “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хяналт-шинжилгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшнийг Хангайн бүс, Баруун бүс, Хойт бүс, Төвийн бүс, Зүүн бүс, Говийн бүс, Улаанбаатарын бүс гэсэн 7 бүсээр ангилан баталсан боловч Засгийн газар, холбогдох бусад байгууллагуудаас шалгуур үзүүлэлтийн хүрээнд тайлан ирүүлээгүй тул бүсчилсэн хөгжлийн бодлогын шалгуур үзүүлэлтэд дүн шинжилгээ хийх боломжгүй байна.

## 2. “Хүний хөгжлийн бодлого”-ын хэрэгжилт

“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн “Хүний хөгжлийн бодлого”-ын хүрээнд 4 чиглэл, 15 зорилго, 152 зорилтын хэрэгжилтийг Засгийн газрын Хянадт хэрэгжүүлэх газраас 50 хувьтай үнэлсэн бол Улсын Их Хурлын Тамгын газраас 25.3 хувь буюу “үр дүнгүй” гэж үнэллээ.

Тус бодлогын хүрээнд дүн шинжилгээ хийсэн нийт 152 зорилтыг хэрэгжилтийг үнэлгээний ангиллаар авч үзвэл:

Хүснэгт 5. “Хүний хөгжлийн бодлого”-ын 2024 оны хэрэгжилт, үнэлгээний ангиллаар, хувь


| Хэрэгжилт                                                        | Зорилтын тоо | Хувь |
|------------------------------------------------------------------|--------------|------|
| - Үр дүнтэй буюу 100 хувийн хэрэгжилттэй                         | 2            | 1.3  |
| - Тодорхой үр дүнд хүрсэн буюу 70-100 хүртэл хувийн хэрэгжилттэй | 7            | 4.6  |
| - Эрчимжүүлэх шаардлагатай буюу 30-70 хүртэл хувийн хэрэгжилттэй | 62           | 40.8 |
| - Үр дүнгүй буюу 0-30 хүртэл хувийн хэрэгжилттэй                 | 40           | 26.3 |
| - Хэрэгжүүлэх хугацаа болоогүй                                   | 41           | 27.0 |
| Нийт                                                             | 152          | 100  |

Тус бодлогын хүрээнд хэрэгжүүлсэн 4 чиглэлийн дундаж үнэлгээг хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт 6. “Хүний хөгжлийн бодлого”-ын 2024 оны хэрэгжилт

| №    | Чиглэл                            | Зорилгын тоо | Зорилтын тоо | УИХТГ-ын үнэлгээ  |    |    |    |    |    |    |             |
|------|-----------------------------------|--------------|--------------|-------------------|----|----|----|----|----|----|-------------|
|      |                                   |              |              | Хэрэгжилтийн хувь |    |    |    |    |    |    | дундаж хувь |
|      |                                   |              |              | 100               | 90 | 70 | 50 | 30 | 0  | ХБ |             |
| 1    | 2.1.Чинээлэг монгол хүн           | 4            | 68           | 2                 | 2  | 5  | 7  | 17 | 13 | 22 | 34.6        |
| 2    | 2.2.Эрдэм боловсролтой монгол хүн | 4            | 41           | -                 | -  | -  | 2  | 23 | 7  | 9  | 24.7        |
| 3    | 2.3.Эрүүл монгол хүн              | 4            | 18           | -                 | -  | -  | 1  | 6  | 10 | 1  | 13.5        |
| 4    | 2.4.Баялагтай эзэн монгол хүн     | 3            | 25           | -                 | -  | -  | 1  | 5  | 10 | 9  | 12.5        |
| Нийт |                                   | 15           | 152          | 2                 | 2  | 5  | 11 | 51 | 40 | 41 | 25.3        |

Зураг 2.Хүний хөгжлийн бодлогын 2024 оны хэрэгжилт (чиглэл бүрээр)



Тус бодлогын 2.1-д заасан “Чинээлэг монгол хүн” чиглэлийн хэрэгжилт:

Гэр бүл, хүн амын онцлогт нийцсэн бодлого /зорилго/-ын хүрээнд:

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 120 дугаар тогтоолоор Нийгмийн даатгалын сангаас олгож байгаа болон цэргийн тэтгэвэр авагчийн тэтгэврийн хэмжээг 100 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээг 540 мянга, бүрэн тэтгэврийн доод хэмжээг 650 мянган төгрөгт хүргэж нэмэгдүүлсэн.

Мөн Нийгмийн даатгалын сангаас олгох бүх төрлийн тэтгэврийн хэмжээг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс инфляцын түвшинтэй уялдуулан 6 хувиар нэмэгдүүлсэн байна. Ингэснээр “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т тусгасан “тэтгэврийн хэмжээг өмнөх оны инфляцын жилийн дундаж болон хүн амын амьжиргааны доод түвшинтэй уялдуулан жил бүр нэмэгдүүлнэ.” гэсэн зорилтын хэрэгжилт хангагдсан байна.

Хөдөлмөр эрхлэлт зорилгын хүрээнд:

Төрийн албан хаагчдын үндсэн цалинг инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэх зарчмыг баримтлан Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолоор 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 6 хувиар нэмэгдүүлэн тогтоосноор “Монгол хүний хөдөлмөрийн бүтээмж, цалин хөлсийг жил бүр нэмэгдүүлэх” зорилтын хэрэгжилт хангагдсан байна.

Асуудал 1. “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр” батлагдаад 6 сар өнгөрч байгаа, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний нарийвчилсан төлөвлөгөө батлагдаагүй зэрэг хүчин зүйлээс шалтгаалан “Чинээлэг монгол хүн” чиглэлийн хүрээнд дэвшүүлсэн 68 зорилтын 44.1 хувь нь “үр дүнгүй” буюу “0-30 хүртэл” хувийн хэрэгжилттэй байгаа бол 32.4 хувь нь хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй байна.



Тус чиглэлийн хэрэгжилт хангалтгүй байгаа зорилтыг нийтлэг шалтгаанаар ангилан харуулбал:

Хүснэгт 7. Хэрэгжилт хангалтгүй шалтгаан

| № | Хэрэгжилт хангалтгүй зорилтын нийтлэг шалтгаан                                               | Тоо       | Зорилтын дугаар                                                                               |
|---|----------------------------------------------------------------------------------------------|-----------|-----------------------------------------------------------------------------------------------|
| 1 | Зорилтын үр дүнг тайланд тусгаагүй                                                           | 4         | 2.1.1.15; 2.1.2.8; 2.1.3.4; 2.1.3.9                                                           |
| 2 | Зорилтыг хангахад чиглэсэн ажлыг тайлагнаагүй, зорилтын агуулгаас зөрүүтэй ажлыг тайлагнасан | 10        | 2.1.1.4; 2.1.1.16; 2.1.1.18; 2.1.1.25; 2.1.1.28; 2.1.1.29; 2.1.2.1; 2.1.2.6; 2.1.4.2; 2.1.4.4 |
| 3 | Биелэлтийг бүрэн тайлагнаагүй                                                                | 8         | 2.1.1.5; 2.1.1.7; 2.1.1.9; 2.1.1.23; 2.1.1.24; 2.1.3.7; 2.1.3.12; 2.1.3.13                    |
| 4 | Зохион байгуулалт хангалтгүй                                                                 | 4         | 2.1.1.6; 2.1.1.26; 2.1.3.6; 2.1.3.14                                                          |
| 5 | Салбар хоорондын уялдаа холбоо хангагдаагүй                                                  | 1         | 2.1.1.27                                                                                      |
|   | <b>Нийт</b>                                                                                  | <b>27</b> |                                                                                               |

Дээрх хүснэгтээс харахад зорилтыг хангахад хэрэгжүүлсэн ажлыг бүрэн гүйцэд тайлагнахгүй орхигдуулах, зорилтын агуулгаас зөрүүтэй ажлыг тайлагнах, хийсэн ажлын биелэлтийг бүрэн тайлагнахгүй байх, тухайн зорилтын үр дүнг тайланд тусгахгүй орхигдуулах зэрэг тайлагналттай холбоотой нийтлэг зөрчил байна. Харин тухайн зорилтын хэрэгжилт хангалтгүй байхад нөлөөлсөн шалтгаан нөхцөлийг нийтлэгээр тайлбарлаагүй орхигдуулсан нь хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журмыг баримтлаагүйг илтгэж байна.

*Тус бодлогын 2.2-т заасан “Эрдэм боловсролтой монгол хүн” чиглэлийн хэрэгжилт*

“Эрдэм боловсролтой монгол хүн” чиглэлд 4 зорилго, 41 зорилт төлөвлөн 24.7 хувийн биелэлттэй байгаа бөгөөд нийт зорилтын үнэлгээг авч үзвэл:

- “эрчимжүүлэх шаардлагатай” буюу 30-70 хүртэл хувийн хэрэгжилттэй 25 зорилт;
- “үр дүнгүй” буюу 0-30 хүртэл хувийн хэрэгжилттэй 7 зорилт;
- “хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй” 9 зорилт байна.

Тус чиглэлийн хүрээний хэрэгжилт хангалтгүй байгаа зорилтыг нийтлэг шалтгаанаар ангилан харуулбал:

Хүснэгт 8. Хангалтгүй зорилтын нийтлэг шалтгаан

| № | Хэрэгжилт хангалтгүй зорилтын нийтлэг шалтгаан              | Тоо | Зорилтын дугаар                                                 |
|---|-------------------------------------------------------------|-----|-----------------------------------------------------------------|
| 1 | Зорилтын үр дүнг тайланд тусгаагүй                          | 3   | 2.2.1.6, 2.2.1.13, 2.2.1.16                                     |
| 2 | Дүрэм, төлөвлөгөөний төсөл боловсруулалтын үе шатанд байгаа | 7   | 2.2.1.4, 2.2.1.7, 2.2.1.8, 2.2.1.9, 2.2.1.11, 2.2.1.14, 2.2.1.5 |
| 3 | Биелэлтийг бүрэн тайлагнаагүй                               | 3   | 2.2.1.1, 2.2.1.3, 2.2.1.10                                      |
| 4 | Салбар хоорондын уялдаа холбоо хангагдаагүй                 | 1   | 2.2.1.2                                                         |

*Биелэлтийг бүрэн тайлагнаагүй хүрээнд:*

“Дижитал шилжилт, технологийн өөрчлөлт, шинэчлэлийн сорилтыг даван туулах чадвартай, монголын түүх, хэл, соёл, үндэсний өв уламжлал, зан заншил, эх оронч хүмүүжлийг олгох боловсролын үндэсний хөтөлбөрийг хөгжүүлнэ” гэсэн 2.2.1.1 дэх зорилтын хүрээнд цахим ур чадварын сургагч багш нарыг бэлтгэж, бага боловсролын сургалтын хөтөлбөрийн төсөл, 2024-2025 оны хичээлийн жилийн 1,2 дугаар улиралд турших сурах бичгийн эхийг тус тус боловсруулсан бөгөөд Монгол Улсын Засгийн газрын тухай хууль /1993.05.06/-ийн 2.2.1.1-д заасан "... боловсролын Үндэсний хөтөлбөр"-ийг баталж хэрэгжүүлсэн эсэхийг тайланд тусгаагүй байна.

“Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг их өгөгдөлд суурилан тооцоолж, шаардлагатай хүний нөөцийг бэлтгэнэ” гэсэн 2.2.1.3 дахь зорилтын хүрээнд хөдөлмөрийн зах зээлийн

эрэлтийг их өгөгдөлд суурилан тооцоолох арга хэмжээний хэрэгжилт, үр дүнг тусгаагүй байна.

*Холбогдох төлөвлөгөө батлаагүй хүрээнд :*

“Хот, суурин газрын сургууль, цэцэрлэгийн бүлэг дүүргэлтийг стандартын түвшинд хүргэх “Нэг ээлж, цөөн хүүхэдтэй анги”, “Гэрт ойр сургууль/цэцэрлэг-хамгийн сайн сургууль/цэцэрлэг” арга хэмжээг хэрэгжүүлнэ” гэсэн 2.2.1.5 дахь зорилтын хүрээнд “Нэг ээлж, цөөн хүүхэдтэй анги”, “Гэрт ойр сургууль/цэцэрлэг-хамгийн сайн сургууль/цэцэрлэг” арга хэмжээний удирдамж, төлөвлөгөөг батлуулаагүй байна.

2.2.1.14-т заасан “Сургуульд суурилсан хүүхдийн эрүүл мэндийн эрт илрүүлгийн үндэсний тогтолцоог бий болгоно” гэсэн зорилтын хүрээнд Нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн 1 дүгээр ангийн 2,666 суралцагчдыг хамруулсан эрт илрүүлгийн үзлэгийн үр дүнг тайланд тусгасан боловч “Эрүүл-аюулгүй сургууль” арга хэмжээ, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлуулаагүй байна.

*Уялдаа холбоо хангагдаагүй хүрээнд:*

2.2.1.16-д заасан “Бүх түвшний боловсролын сургалтын байгууллагын дотуур байрны хүртээмж, орчин, үйлчилгээний чанарыг сайжруулж, хүний эрхэд ээлтэй дотуур байрыг бий болгоно” гэсэн зорилтын хэрэгжилтийг ХЗДХЯ-аас бусад төрийн захиргааны төв байгууллагын хэрэгжүүлсэн арга хэмжээг тусгаагүй байна.

*Тус бодлогын 2.3-т заасан “Эрүүл монгол хүн” чиглэлийн хэрэгжилт:*

“Эрүүл монгол хүн” чиглэлд 4 зорилго, 18 зорилт төлөвлөн 13.5 хувийн биелэлттэйгээр хэрэгжүүлсэн бөгөөд нийт зорилтын үнэлгээг авч үзвэл “эрчимжүүлэх шаардлагатай” буюу 30-70 хүртэл хувийн хэрэгжилттэй 7 зорилт, “үр дүнгүй” буюу 0-30 хувийн хэрэгжилттэй 10 зорилт, “хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй” 1 зорилт байна.

Тус чиглэлийн хүрээний хэрэгжилт хангалтгүй байгаа зорилтыг нийтлэг шалтгаанаар ангилан харуулбал:

Хүснэгт 9. Хангалтгүй зорилтын нийтлэг шалтгаан

| № | Хэрэгжилт хангалтгүй зорилтын нийтлэг шалтгаан                                               | Тоо       | Зорилтын дугаар                    |
|---|----------------------------------------------------------------------------------------------|-----------|------------------------------------|
| 1 | Зорилтын хэрэгжилтийг бүрэн тусгаагүй                                                        | 3         | 2.3.1.1, 2.3.1.3, 2.3.2.3          |
| 2 | Боловсруулалтын шатанд байгаа                                                                | 2         | 2.3.2.1, 2.3.4.1                   |
| 3 | Ямар нэг арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй                                                      | 3         | 2.3.2.4, 2.3.2.7, 2.3.2.8          |
| 4 | Ажлын хэсэг ажиллаж байгаа, бэлтгэл хангахтай холбоотой үйл ажиллагааг авч хэрэгжүүлж байгаа | 4         | 2.3.2.2, 2.3.2.5, 2.3.3.2, 2.3.4.2 |
| 5 | Ажил тодорхой хэмжээнд эхэлсэн                                                               | 1         | 2.3.2.6                            |
| 6 | Журам, хөтөлбөр батлагдаагүй                                                                 | 1         | 2.3.3.1                            |
| 7 | Үр дүнг тайлагнаагүй                                                                         | 3         | 2.3.1.2, 2.3.3.3, 2.3.4.3          |
|   | <b>Нийт</b>                                                                                  | <b>17</b> |                                    |

*“0” хувийн үнэлгээтэй буюу ямар нэг арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй зорилтын хүрээнд:*

2.3.1.2.Хүн амын өвчлөл, нас баралтын тэргүүлэх шалтгааныг бууруулах, эрүүл мэндэд эрсдэл үүсгэж байгаа хүчин зүйлс, архи, тамхины хэрэглээг бууруулж, гар утсанд суурилсан стратегийн тусламжтайгаар иргэдийн эрүүл мэндийг хамгаалж, идэвхтэй хөдөлгөөн, эрүүл хооллолтыг дэмжинэ” гэсэн зорилтын хүрээнд үйл ажиллагааны тайлан ирүүлээгүй байна.

2.3.2.4-т заасан “Маш цөөн хийгддэг, өндөр зардалтай тусламж, үйлчилгээг гадаад улсын эмнэлэгтэй хамтын гэрээ байгуулж, тусламж, үйлчилгээ үзүүлэх боломжийг бүрдүүлнэ” гэсэн зорилт, 2.3.2.7-д заасан “Эрүүл мэндийн мэдээллийн нэгдсэн санг олон

улсын стандартын дагуу бүрдүүлж, их өгөгдөл үүсгэнэ” гэсэн зорилт, 2.3.2.8-д заасан “Сэргээн засах тусламж, үйлчилгээг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлж, тусламж, үйлчилгээ шаардлагатай иргэдэд урт болон богино хугацаагаар, цогц байдлаар, нотолгоонд суурилсан тусламж, үйлчилгээг үзүүлж, чанар, аюулгүй байдлыг хангана” гэсэн зорилтыг тус тус хэрэгжүүлээгүй байна.

#### *Тус бодлогын 2.4-т заасан “Баялагтаа эзэн монгол хүн” чиглэлийн хэрэгжилт*

“Баялагтаа эзэн монгол хүн” чиглэлд 3 зорилго, 25 зорилт төлөвлөн 12.5 хувийн биелэлттэйгээр хэрэгжүүлсэн бөгөөд нийт зорилтын үнэлгээг авч үзвэл “эрчимжүүлэх шаардлагатай” буюу 30-70 хүртэл хувийн хэрэгжилттэй 6 зорилт, “үр дүнгүй” буюу 0-30 хувийн хэрэгжилттэй 10 зорилт, “хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй” 9 зорилт байна.

Тус чиглэлийн хүрээний хэрэгжилт хангалтгүй байгаа зорилтыг нийтлэг шалтгаанаар ангилан харуулбал:

Хүснэгт 10. Хангалтгүй зорилтын нийтлэг шалтгаан

| № | Хэрэгжилт хангалтгүй зорилтын нийтлэг шалтгаан                                               | Тоо       | Зорилтын дугаар                                      |
|---|----------------------------------------------------------------------------------------------|-----------|------------------------------------------------------|
| 1 | Боловсруулалтын шатанд байгаа                                                                | 2         | 2.4.3.4, 2.4.3.7                                     |
| 2 | Ямар нэг арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй                                                      | 2         | 2.4.1.2, 2.4.1.3                                     |
| 3 | Ажлын хэсэг ажиллаж байгаа, бэлтгэл хангахтай холбоотой үйл ажиллагааг авч хэрэгжүүлж байгаа | 6         | 2.4.1.1, 2.4.2.1, 2.4.2.8, 2.4.3.1, 2.4.1.7, 2.4.3.2 |
| 4 | Ажил тодорхой хэмжээнд эхэлсэн                                                               | 1         | 2.4.2.5                                              |
| 5 | Журам, хөтөлбөр батлагдаагүй                                                                 | 2         | 2.4.1.4, 2.4.1.5                                     |
| 6 | Үр дүнг тайлагнаагүй                                                                         | 4         | 2.4.1.6, 2.4.2.2, 2.4.1.8, 2.4.2.4                   |
| 7 | Ажлын уялдаа холбоог хангах талаар тайлагнаагүй                                              | 1         | 2.4.3.8                                              |
|   | <b>Нийт</b>                                                                                  | <b>18</b> |                                                      |

#### *Зорилтын хэрэгжилтийн үр дүнг тусгаагүй хүрээнд:*

2.3.4.3-т заасан “Эрүүл мэндийн ажилтны нийгмийн баталгааг сайжруулж, алслагдсан орон нутагт ажиллаж байгаа эрүүл мэндийн ажилтанд олгох төрийн дэмжлэг, хөнгөлөлт, урамшууллыг нэмэгдүүлнэ” гэсэн зорилтыг хэрэгжүүлэхэд Төрийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/ /2017.12.07/-ийн 61-р зүйлд заасан төрийн албан хаагч буюу “эрүүл мэндийн ажилтны” нийтлэг 10 төрлийн баталгаа, 62-р зүйлд заасан нэмэгдэл 3 төрлийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн, үр нөлөөг тайланд тусгаагүй байна.

#### *Ажлын уялдаа холбоог хангах талаар тайлагнаагүй хүрээнд:*


2.4.3.8-д заасан “Зам, замын байгууламжийг хотын инженерийн бэлтгэл арга хэмжээний нэгдсэн төлөвлөлттэй уялдуулж, ус зайлуулах шугам сүлжээг барьж байгуулна” гэсэн зорилтын хүрээнд Зам, тээврийн хөгжлийн яам тайланг ирүүлсэн бөгөөд Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, Нийслэлийн Засаг дарга Тамгын газар зэрэг бусад холбогдох байгууллага буюу хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг нэгтгэж хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланд тусгаагүй байна.

### **3. “Эдийн засгийн бодлого”-ын хэрэгжилт**

“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн “Эдийн засгийн бодлого”-ын хүрээнд 4 чиглэл, 15 зорилго, 222 зорилтын хэрэгжилтийг Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас 50 хувь гэж үнэлсэн бол Улсын Их Хурлын Тамгын газраас 25.5 хувь буюу “үр дүнгүй” гэж үнэллээ.

Тус бодлогын хүрээнд дүн шинжилгээ хийсэн нийт 222 зорилтыг хэрэгжилтийг авч үзвэл:

Зураг 3. Эдийн засгийн бодлогын 2024 оны хэрэгжилт (чиглэл бүрээр)



Тус бодлогын хүрээнд хэрэгжүүлсэн 4 чиглэлийн дундаж үнэлгээг хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт 11. “Бүсчилсэн хөгжлийн хөгжлийн бодлого”-ын 2024 оны хэрэгжилт

| №    | Чиглэл                                                       | Зорилгын<br>Тоо | Зорилтын<br>Тоо | УИХТГ-ын үнэлгээ  |    |    |    |    |    |    |                |
|------|--------------------------------------------------------------|-----------------|-----------------|-------------------|----|----|----|----|----|----|----------------|
|      |                                                              |                 |                 | Хэрэгжилтийн хувь |    |    |    |    |    |    | дундаж<br>хувь |
|      |                                                              |                 |                 | 100               | 90 | 70 | 50 | 30 | 0  | ХБ |                |
| 1    | 3.1.Эдийн засгийн эрх чөлөө                                  | 3               | 18              | -                 | 2  | -  | 2  | 3  | 3  | 8  | 37.0           |
| 2    | 3.2.Бизнес, хөрөнгө оруулалтын орчин                         | 2               | 23              | -                 | 2  | 2  | 1  | 3  | 6  | 9  | 32.9           |
| 3    | 3.3.Эдийн засгийн төрөлжилт, либералчлал                     | 7               | 154             | 1                 | 1  | 4  | 16 | 38 | 54 | 40 | 21.1           |
| 4    | 3.4.Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлт, ногоон санхүүжилт | 3               | 27              | -                 | -  | 3  | 8  | 10 | 4  | 2  | 36.4           |
| нийт |                                                              | 15              | 222             | 1                 | 5  | 9  | 27 | 54 | 67 | 59 | 25.5           |

**Тус бодлогын 3.1-д заасан “Эдийн засгийн эрх чөлөө” чиглэлийн хэрэгжилт:**

Тус чиглэлийн хүрээнд “Макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах”, “Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өргөжүүлэх”, “Банк, санхүү, даатгалын салбарыг шинэчлэх” гэсэн 3 зорилго, 18 зорилтын хэрэгжилт 37.0 хувь байна.

Нийт 18 зорилтын үнэлгээ тус бүрээр авч үзвэл:

- “тодорхой үр дүнд хүрсэн” буюу 70-100 хүртэл хувийн хэрэгжилттэй 2 зорилт;
- “эрчимжүүлэх шаардлагатай” буюу 30-70 хүртэл хувийн хэрэгжилттэй 5 зорилт;
- “үр дүнгүй” буюу 0-30 хүртэл хувийн хэрэгжилттэй 3 зорилт;
- “хэрэгжих хугацаа болоогүй” 8 зорилт байна.

Засгийн газрын өрийн нэрлэсэн үлдэгдлийн ДНБ-д эзлэх хэмжээ 2024 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 42.2 хувь байгаа нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан Засгийн газрын өрийн тусгай шаардлага болох 60 хувиас хэтрэхгүй байх заалтыг хангасан байна.

*Тус бодлогын 3.2-т заасан “Бизнес, хөрөнгө оруулалтын орчин” чиглэлийн хэрэгжилт:*

Тус чиглэлийн хүрээнд “Татвар, нийгмийн даатгалын шинэчлэлийг хийх”, “Бизнес, хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэх” гэсэн 2 зорилго, 23 зорилтын хэрэгжилт 32.9 хувьтай байна.

Нийт 23 зорилтын үнэлгээ тус бүрээр нь авч үзвэл:

- “тодорхой үр дүнд хүрсэн” буюу 70-100 хүртэл хувийн хэрэгжилттэй 4 зорилт;
- “эрчимжүүлэх шаардлагатай” буюу 30-70 хүртэл хувийн хэрэгжилттэй 4 зорилт;
- “үр дүнгүй” буюу 0-30 хүртэл хувийн хэрэгжилттэй 6 зорилт;
- “хэрэгжих хугацаа болоогүй” 9 зорилт байна.

*Тус бодлогын 3.3-т заасан “Эдийн засгийн төрөлжилт, либералчлал” чиглэлийн хэрэгжилт:*

Тус чиглэлийн хүрээнд төлөвлөсөн 7 зорилго, 154 зорилтын хэрэгжилт дунджаар 21.1 хувь байна.

Нийт 154 зорилтын үнэлгээ тус бүрээр авч үзвэл:

- “үр дүнтэй” буюу 100 хувийн хэрэгжилттэй 1 зорилт;
- “тодорхой үр дүнд хүрсэн” буюу 70-100 хүртэл хувийн хэрэгжилттэй 5 зорилт;
- “эрчимжүүлэх шаардлагатай” буюу 30-70 хүртэл хувийн хэрэгжилттэй 54 зорилт;
- “үр дүнгүй” буюу 0-30 хүртэл хувийн хэрэгжилттэй 54 зорилт;
- “хэрэгжих хугацаа болоогүй” 40 зорилт байна.

3.3.2-т заасан “Боомтын шинэчлэл, тээвэр, логистик” зорилгын хүрээнд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын гэрээнээс шалтгаалан хүлээгдэж байна. Мөн Улаанбаатар хотыг Шивээхүрэн боомттой холбосон авто замын санхүүжилт улсын төсөвт тусгагдаагүйн улмаас хэрэгжээгүй байна.

Бусад зорилтын хувьд үр бэлтгэл ажил эхэлсэн ч үр дүн гарч эхлээгүй, бэлтгэл ажил хийгдэж байгаа нь дундаж хэрэгжилт багаар үнэлэгдэхэд нөлөөлж байна.

*Тус бодлогын 3.4-т заасан “Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлт, ногоон санхүүжилт” чиглэлийн хэрэгжилт*

Тус чиглэлийн хүрээнд төлөвлөсөн 3 зорилго, 27 зорилтын хэрэгжилт дунджаар 36.4<sup>2</sup> хувьтай байна.

Нийт 27 зорилтын үнэлгээ тус бүрээр авч үзвэл:

- “тодорхой үр дүнд хүрсэн” буюу 70-100 хүртэл хувийн хэрэгжилттэй 3 зорилт;
- “эрчимжүүлэх шаардлагатай” буюу 30-70 хүртэл хувийн хэрэгжилттэй 18 зорилт;
- “үр дүнгүй” буюу 0-30 хүртэл хувийн хэрэгжилттэй 4 зорилт;
- “хэрэгжих хугацаа болоогүй” 2 зорилт байна.

#### **4. “Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого”-ын хэрэгжилт**

“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн “Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого”-ын хүрээнд 4 чиглэл, 16 зорилго, 154 зорилтын хэрэгжилтийг Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас 50 хувьтай үнэлсэн бол Улсын Их Хурлын Тамгын газраас 26.7 хувь буюу “үр дүнгүй” гэж үнэллээ.

---


<sup>2</sup> Нийт төлөвлөсөн 27 зорилтоос хугацаа болоогүй гэж тайлагнасан 2 зорилтыг хасаж 25 зорилтын арифметик дундажаар тооцсон болно.

Тус бодлогын хүрээнд дүн шинжилгээ хийсэн нийт 154 зорилтыг хэрэгжилтийн хувь тус бүрээр авч үзвэл:

Хүснэгт 11. “Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого”-ын хэрэгжилт

| Хэрэгжилт                                                      | Зорилтын тоо | Хувь |
|----------------------------------------------------------------|--------------|------|
| Тодорхой үр дүнд хүрсэн буюу 70-100 хүртэл хувийн хэрэгжилттэй | 5            | 33   |
| Эрчимжүүлэх шаардлагатай буюу 30-70 хүртэл хувийн хэрэгжилттэй | 57           | 37.  |
| Үр дүнгүй буюу 0-30 хүртэл хувийн хэрэгжилттэй                 | 33           | 21.4 |
| Хэрэгжүүлэх хугацаа болоогүй                                   | 59           | 38.3 |
| Нийт                                                           | 154          | 100  |

Зураг 4. Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлогын хэрэгжилт (чиглэл бүрээр)



Тус бодлогын хүрээнд хэрэгжүүлсэн 4 чиглэлийн дундаж үнэлгээг хүснэгтээр үзүүлбэл:


Хүснэгт 12. “Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого”-ын 2024 оны хэрэгжилт

| №    | Чиглэл                                                    | Зорилгын тоо | Зорилтын тоо | УИХТГ-ын үнэлгээ  |    |    |    |    |    |    |             |
|------|-----------------------------------------------------------|--------------|--------------|-------------------|----|----|----|----|----|----|-------------|
|      |                                                           |              |              | Хэрэгжилтийн хувь |    |    |    |    |    |    | дундаж хувь |
|      |                                                           |              |              | 100               | 90 | 70 | 50 | 30 | 0  | ХБ |             |
| 1    | 4.1.Хүний эрх, эрх чөлөө                                  | 5            | 33           | -                 | -  | 3  | 4  | 7  | 5  | 14 | 32.6        |
| 2    | 4.2.Авлигагүй засаглал                                    | 4            | 39           | -                 | -  | -  | 4  | 8  | 16 | 11 | 15.7        |
| 3    | 4.3.Цахим засаглал, төрийн бүтээмжийн дахин инженерчлэл   | 3            | 19           | -                 | -  | -  | 3  | 3  | 4  | 9  | 24.0        |
| 4    | 4.4.Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх ба амар тайван нийгэм | 4            | 63           | -                 | -  | 2  | 13 | 15 | 8  | 25 | 32.6        |
| НИЙТ |                                                           | 16           | 154          | -                 | -  | 5  | 24 | 33 | 33 | 59 | 26.7        |

Тус бодлогын 4.1-д заасан “Хүний эрх, эрх чөлөө” чиглэлийн хэрэгжилт:

“Хүний эрх, эрх чөлөө” чиглэлийн хүрээнд “Хүний эрх”, “Хэвлэлийн эрх чөлөө”, “Иргэний нийгэм, хувийн хэвшил, төрийн түншлэл, хамтын ажиллагаа”, “Ил тод байдал ба хяналт”, “Шүүх засаглал” гэсэн 5 зорилго, 33 зорилтын хэрэгжилт 32.6 хувьтай буюу хэрэгжилтийг “эрчимжүүлэх шаардлагатай” байна.

Зураг 5. Хэрэгжилтийн байдал



Тус чиглэлийн 33 зорилтын 15.2 хувь /5

зорилт/ нь үр дүнгүй, 42.4 хувь /14 зорилт/-ийг “хэрэгжүүлэх хугацаа болоогүй” байгаа нь дараах хэд хэдэн хүчин зүйл нөлөөлсөн гэж үзлээ. Үүнд:

- зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд хийгдсэн ажлыг бүрэн тайлагнаагүй;
- гарсан үр дүн бус үйл явцыг тайлагнасан;
- зорилтын хэрэгжилт хангалтгүй байхад нөлөөлсөн шалтгаан нөхцөлийг тайлбарлаагүй орхигдуулсан нь хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд хүндрэлтэй байдлыг үүсгэж байна.

#### *Тус бодлогын 4.2-т заасан “Авлигагүй засаглал” чиглэлийн хэрэгжилт:*

Тус чиглэлийн хүрээнд “Авлига, гэмт хэрэгтэй тэмцэх, хууль сахиулах үйл ажиллагаа”, “Дэвшилтэт технологид суурилсан цахим засаглал”, “Төрийн албаны шинэчлэл”, “Орон нутгийн засаглалын бие даасан байдал” гэсэн 4 зорилго, 39 зорилтын хэрэгжилт дунджаар 15.7 хувь буюу “үр дүнгүй” байна.

Тус чиглэлийн хүрээнд хэрэгжүүлсэн нийт 39 зорилтын үнэлгээ тус бүрээр авч үзвэл “эрчимжүүлэх шаардлагатай” буюу 30-70 хүртэл хувийн хэрэгжилттэй 12 зорилт, “үр дүнгүй” буюу 0-30 хүртэл хувийн хэрэгжилттэй 16 зорилт, “хэрэгжүүлэх хугацаа болоогүй” 11 зорилт байна.

Асуудал 1. Авлигагүй засаглал чиглэлийн хүрээнд нийт 18 зорилтын хэрэгжилт 0 хувьтай, 8 зорилтын хэрэгжилт 30 хувьтай буюу “үр дүнгүй” зорилтын нийт зорилтод эзлэх хувь 89.6 байгаа нь Авлигагүй засаглал зорилтын хэрэгжилт хангалтгүй байхад хүргэж байна. Өөрөөр хэлбэл, тус чиглэлийн хүрээнд хэрэгжилтийг тайлагнасан 29 зорилтоос тухайн зорилтыг хэрэгжүүлэхээр ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байгаа, бэлтгэл хангахтай холбоотой үйл ажиллагааг авч хэрэгжүүлж эхэлсэн 16, зорилтын хэрэгжилтийн үр дүнг тусгаж бүрэн тайлагнаагүй 10, зорилтын хүрээнд батлагдах хууль, дүрэм, журам батлагдаагүй 2 зорилт байгаа бол хэрэгжилтийн тайланг ирүүлээгүй 1 зорилт/4.2.1.15/ байна.

4.2.1.1-д заасан “Авлига, албан тушаалын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх бодлого, эрх зүйн шинэчлэлийг эрчимжүүлэх” зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх тухай хуулийн төсөл, Түр хураасан, хураан авсан, царцаасан хөрөнгийг эрхлэн удирдах тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлснээр авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй тэмцэх бодлого, эрх зүйн шинэчлэлийг эрчимжүүлсэн гэж үзэх боломжгүй юм.

Тухайлбал, Үндэсний статистикийн хорооны авлига, албан тушаалын гэмт хэргийн талаарх статистик мэдээллээс харахад 2020 оноос хойш авлигын гэмт хэргийн тоо тасралтгүй өссөн үзүүлэлттэй тул үнэлгээг бууруулж 50 хувиар үнэлсэн болно.

Хүснэгт 13.Авлигын гэмт хэргийн тоо

| Гэмт хэргийн ангилал                                 | 2020 | 2021 | 2022 | 2023 | 2024 |
|------------------------------------------------------|------|------|------|------|------|
| Авлигын гэмт хэрэг                                   | 314  | 335  | 475  | 569  | 577  |
| - Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах | 219  | 237  | 364  | 423  | 433  |
| - Хахууль авах                                       | 67   | 74   | 79   | 99   | 85   |
| - Хахууль өгөх                                       | 40   | 45   | 37   | 53   | 67   |

Асуудал 2. Дэвшилтэт технологид суурилсан цахим засаглалыг хэрэгжүүлэх



зорилгын хүрээнд хэрэгжүүлэх “Төрийн тогтолцооны цахим дэд бүтцийг хөгжүүлж, шийдвэр гаргах үйл явцыг хурдан, ил тод, нээлттэй болгох”, “Төлөвлөлт, хэрэгжилт, хяналт, зөвшөөрлийн тогтолцоог шинэчилж, бүрэн цахимжуулан төрийн захиргааны үйл ажиллагааг идэвхжүүлэх ба төрийн албан хаагчдыг тогтмол чадавхжуулах”, “төрийн үйл ажиллагааны хурд, бүтээмжийг дээшлүүлж, иргэдэд түргэн шуурхай хялбар, үйлчилгээ үзүүлэх цахим төрийн тогтолцоонд шилжих” зорилтуудыг хэрэгжүүлэхэд шаардлагатай тооцоо, судалгаа хийх, асуудал тодорхойлох зэрэг бэлтгэл хангахтай холбогдсон үйл ажиллагааг авч эхэлж байгаа тул зорилтын хэрэгжилт үр дүнгүй гарахад нөлөөлж байна.

Харин тухайн зорилтын хэрэгжилт хангалтгүй байхад нөлөөлсөн шалтгаан нөхцөлийг нийтлэг байдлаар үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, төсөв батлагдаагүйтэй холбоотой байна.

*Тус бодлогын 4.3-т заасан “Цахим засаглал, төрийн бүтээмжийн дахин инженерчлэл” чиглэлийн хэрэгжилт:*

Тус чиглэлийн хүрээнд “E-Mongolia”-блокчейн-Цахим засаглал”, “Сансар судлал, харилцаа холбоо, мэдээлэл технологи”, “Цахим орчин дахь хүний эрх, кибер аюулгүй байдал” гэсэн 3 зорилго, 19 зорилтын хэрэгжилт 32.6 хувьтай буюу хэрэгжилтийг “эрчимжүүлэх шаардлагатай” байна. Тус чиглэлийн хүрээнд хэрэгжүүлсэн нийт 19 зорилтоос 31.6 хувь /6 зорилт/ нь эрчимжүүлэх шаардлагатай, 21.1 хувь /4 зорилт/ нь үр дүнгүй, 47.3 хувь /9 зорилт/-ийг “хэрэгжүүлэх хугацаа болоогүй” байна.

Дээрх зорилтуудын хэрэгжилтийг тайлагнасан байдлаас харахад хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, төсөв хөрөнгө батлагдаагүй, зорилт, арга хэмжээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин тодорхойгүйгээс удирдлага зохион байгуулалтын хувьд арга хэмжээ авч ажиллаагүй, салбар хоорондын уялдаа хангагдаагүй, бэлтгэл ажил дуусаагүй, тодорхой үр дүн гарч эхлээгүй, авсан арга хэмжээ, үр дүнг бүрэн тайлагнаагүй, гүйцэтгэл дутуу зэрэг шалтгаануудтай холбоотой байна.

Хэрэгжилтийг тайлагнасан 10 зорилтоос ажлын хэсэг байгуулагдан, бэлтгэл ажил хангаж байгаа 7 зорилт, санхүүжилт батлагдаагүй гэх шалтгаантай 1 зорилт/4.3.2.1/, ажил тодорхой хэмжээнд эхэлж үр дүн гарсан 2 зорилт байна.

Иймд Засаглалын бодлогын “Цахим засаглал, төрийн бүтээмжийн дахин инженерчлэл” чиглэлийн хүрээнд хэрэгжүүлэх нийт зорилтын хэрэгжилт үр дүнгүй байгаа тул удирдлага зохион байгуулалтын түвшинд эрчимжүүлэх шаардлагатай байна.

*Тус бодлогын 4.4-д заасан “Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх ба амар тайван нийгэм” чиглэлийн хэрэгжилт:*

Тус чиглэлийн хүрээнд хэрэгжүүлсэн нийт 63 зорилтын үнэлгээ тус бүрээр авч үзвэл:



Энэ чиглэлд 4 зорилго, 63 зорилтын хэрэгжилт 32.6 хувьтай буюу хэрэгжилтийг “эрчимжүүлэх шаардлагатай” байна.

#### **Үнэлгээ бууруулсан үндэслэл:**

“Согтууруулах ундааны эргэлтэд тавих хяналтыг сайжруулж, Архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх сангийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ” гэсэн 4.4.1.11 дэх зорилтын хүрээнд “... согтуугаар үйлдэгдсэн Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг өмнөх оны мөн үеэс 18 нэгжээр буюу 13.7, хөлдөж, осгож амь нас хохирсон хүний тоо



4 нэгж буюу 25 хувиар тус тус буурч, эргүүл хяналт шалгалтын ажил эрчимжсэнээр согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон гэмт хэрэг, зөрчил 110 нэгж буюу 3.9 хувиар өссөн үзүүлэлтэй” гэж үзэж 50 хувийн хэрэгжилттэй гэж тайланд тусгажээ.

Дээрх тайланд дүн шинжилгээ хийхэд Үндэсний статистикийн хорооны албан ёсны мэдээллээр 2024 оны жилийн эцсийн байдлаар “согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг” өмнөх оны мөн үетэй харьцуулахад 33.5 хувиар өссөн үзүүлэлттэй байгаа нь хэрэгжилт хангалтгүй байгаа тул 30 хувийн хэрэгжилттэй гэж үнэллээ.

Хүснэгт 14. Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн тоо

| Он/сар | 2   | 3     | 4     | 5     | 6     | 7     | 8     | 9     | 10    | 11    | 12    | дүн    |
|--------|-----|-------|-------|-------|-------|-------|-------|-------|-------|-------|-------|--------|
| 2024   | 900 | 1,409 | 2,035 | 2,663 | 3,239 | 3,878 | 4,419 | 4,910 | 5,605 | 6,459 | 6,862 | 42,812 |
| 2023   | 713 | 1,133 | 1,543 | 2,024 | 2,498 | 2,847 | 3,289 | 3,749 | 4,198 | 4,730 | 4,979 | 32,064 |

Нийт 63 зорилтын 12.7 хувь /8 зорилт/ нь үр дүнгүй, 39.7 хувь /25 зорилт/-ийг “хэрэгжүүлэх хугацаа болоогүй” байгаа нь дараах хэд хэдэн хүчин зүйл нөлөөлсөн гэж үзлээ. Үүнд:

- Монгол Улсын Их Хурлын “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 2024.08.27-ны өдрийн 21 дүгээр тогтоолын 2.2-т заасан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшний хамт баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах” гэсэн арга хэмжээг хэрэгжүүлээгүй;
- Холбогдох хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээний акт батлагдаагүй. Тухайлбал, 4.4.1.1-д “нийгмийн соён гэгээрлийн бодлого”, 4.4.1.4-д “Эх оронч монгол” хөтөлбөр”, 4.4.2.9 “олон улсын сансар судлалын хамтын ажиллагааны бодлого”, 4.4.3.10-д “зардлын тооцоо” шаардлагатай.
- Зорилтод тусгасан хэд хэдэн арга хэмжээг хэрэгжүүлсэн эсэх нь тодорхой бус буюу хэрэгжилтийг тайлагнаагүй. Тухайлбал, 4.4.2.16 дахь зорилтод заасан бүс нутгийн эдийн засгийн интеграцид нэгдэж, экспортыг нэмэгдүүлэх, төрөлжүүлэх, гадаад худалдаанд тулгарч байгаа хүндрэлүүдийг багасгах, хөнгөвчлөх зорилтын үр дүнг тайланд тусгаагүй байна.
- Бэлтгэл хангах ажил дуусаагүй. /аргачлалын 6.2.2.5-д зааснаар 0 хувьтай/ Тухайлбал, 4.4.2.7, 4.4.3.2, 4.4.5.2 дахь зорилтууд хамаарна.
- “Хэрэгжүүлэх хугацаа болоогүй” зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай зохион байгуулалтын ажил хангалтгүй байна. Тухайлбал, “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан” /2025.01.17/-гийн “Дүгнэлт” хэсэгт “... Зорилтын хэрэгжилт үр дүнгүй байгаа шалтгаан нь хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлагдаагүй хугацаа алдсан, хөтөлбөрт тусгагдсан зорилтууд утга агуулгын хувьд давхардсан, тухайн зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсөв батлагдаагүй, мөн тендер шалгаруулалт, гэрээ байгуулах зэрэг зохион байгуулалтын үйл ажиллагаатай холбоотой байна ...” гэж тайлагнасан байна.

## ХОЁР.БОДЛОГЫН БАРИМТ БИЧГҮҮДИЙН УЯЛДАА

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3.1-д заасны дагуу Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн гүйцэтгэлийн тайланд “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан зорилго, зорилт, хүрэх үр

дүн нь Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгасан зорилго, зорилт, хүрэх үр дүнгийн хэдэн хувьд хүрснийг зорилт, арга хэмжээ тус бүрээр” тусгахаар заасан.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн төсөл, арга хэмжээг төсөв, санхүүгийн тооцоо, эх үүсвэртэй нь уялдуулан нарийвчлан төлөвлөсөн “Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө” батлагдаагүй тул тус заалтын хүрээнд тайлагнаагүй байна.

Дүн шинжилгээний явцад “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т тусгасан 620 зорилт болон “Монгол Улсын 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 176 төсөл, арга хэмжээний уялдаа холбоог харьцуулахад дараах 3 аргыг ашигласан. Үүнд:

- Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгагдсан арга хэмжээг тодорхойлсон текстээс хэдэн тэмдэгтийг өөрчлөхөд Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээ гарахыг арга хэмжээ тус бүрээр тооцоолох “Дамерау-Левэнштейны зай”-г тооцох арга;
- Хиймэл оюун ухааны BERT (Bidirectional Encoder Representations from Transformers) загвар ашиглан арга хэмжээ тус бүр хоорондын ижил төстэй байдлын хувийг тооцох арга;
- Арга хэмжээ тус бүр дэх үгийн давтамжийг ашиглан Векторын аргаар тооцох косинусын ижил төстэй байдлын коэффициент тооцох арга.

“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т тусгасан 620 зорилт болон “Монгол Улсын 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 176 төсөл, арга хэмжээний 28.4 хувь нь агуулгын хувьд ойролцоо байна.

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт заасан арга хэмжээ нь Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд заасан арга хэмжээний хэрэгжилтийн хэдэн хувьд хүрсэн эсэхийг Засгийн газраас ирүүлсэн бодлогын баримт бичгүүдийн хяналт шинжилгээ, үнэлгээний тайлангийн мэдээлэлд үндэслэн тодорхойлох боломжгүй байна.

Хүснэгт 15.Бодлогын баримт бичгийн уялдаа

| № | Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр |                                                                    |              | Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл |      |
|---|--------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------|--------------|-----------------------------------------------------------------|------|
|   | Бодлого                                                            | Чиглэл                                                             | Зорилтын тоо | Арга хэмжээний тоо                                              | Хувь |
| 1 | Бүсчилсэн хөгжлийн бодлого                                         | 1.1.Улаанбаатар хот-"20 минутын хот" стандарт                      | 34           | 7                                                               | 20.6 |
|   |                                                                    | 1.2.Бие даасан эдийн засаг бүхий улсын зэрэглэлтэй хот, дагуул хот | 11           | 2                                                               | 18.2 |
|   |                                                                    | 1.3.Бүсийн төрөлжсөн хөгжил                                        | 31           | 4                                                               | 12.9 |
|   |                                                                    | 1.4.Орон нутгийн хөгжил                                            | 16           | 2                                                               | 12.5 |
| 2 | Хүний хөгжлийн бодлого                                             | 2.1.Чинээлэг монгол хүн                                            | 68           | 24                                                              | 35.3 |
|   |                                                                    | 2.2.Эрдэм боловсролтой монгол хүн                                  | 41           | 11                                                              | 26.8 |
|   |                                                                    | 2.3.Эрүүл монгол хүн                                               | 18           | 9                                                               | 50.0 |
|   |                                                                    | 2.4.Баялагтаа эзэн монгол хүн                                      | 25           | 6                                                               | 24.0 |
| 3 |                                                                    | 3.1.Эдийн засгийн эрх чөлөө                                        | 18           | 5                                                               | 27.8 |
|   |                                                                    | 3.2.Бизнес, хөрөнгө оруулалтын орчин                               | 23           | 4                                                               | 17.4 |

|      |                                           |                                                              |     |     |      |
|------|-------------------------------------------|--------------------------------------------------------------|-----|-----|------|
|      | Эдийн засгийн бодлого                     | 3.3.Эдийн засгийн төрөлжилт, либералчлал                     | 154 | 40  | 26.0 |
|      |                                           | 3.4.Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлт, ногоон санхүүжилт | 27  | 10  | 37.0 |
| 4    | Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого | 4.1.Хүний эрх, эрх чөлөө                                     | 33  | 10  | 30.3 |
|      |                                           | 4.2.Авлигагүй засаглал                                       | 39  | 10  | 25.6 |
|      |                                           | 4.3.Цахим засаглал, төрийн бүтээмжийн дахин инженерчлэл      | 19  | 7   | 36.8 |
|      |                                           | 4.4.Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх ба амар тайван нийгэм    | 63  | 25  | 39.7 |
| Нийт |                                           |                                                              | 620 | 176 | 28.4 |

## ДҮГНЭЛТ

1. Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2024 оны сүүлийн хагас жилийн хэрэгжилтийг **34.0** хувьтай гэж үнэлсэн бол Улсын Их Хурлын Тамгын газраас **25.3** хувь буюу хөтөлбөрийн хэрэгжилт **“үр дүнгүй”** гэж үнэллээ.
2. “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн Бүсчилсэн хөгжлийн бодлого **22.4** хувь, Хүний хөгжлийн бодлого **25.3** хувь, Эдийн засгийн бодлого **25.5** хувь, Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого **26.7** хувь тус тус хэрэгжсэн байна.
3. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3 дахь хэсэг, Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын 2 дахь заалтын 2-т тус тус заасны дагуу “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө” батлагдаагүй, хяналт шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинг 2025 оноос эхлэн тооцохоор тусгасан, хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүжилт батлагдаагүй нь “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн хэрэгжилт **“үр дүнгүй”** байхад нөлөөлж байна.
4. “Монгол Улсын 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн бодлогын баримт бичигт “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 620 зорилтоос 28.4 хувь нь агуулгын хувьд тусгагдсан бол 71.6 хувь нь тусгагдаагүй байгаа ба бодлогын баримт бичгийн уялдаа холбоо хангагдаагүй байна.
5. “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө” батлагдаагүй тул Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3.1-д зааснаар Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан зорилго, зорилт, хүрэх үр дүн нь Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгасан зорилго, зорилт, хүрэх үр дүнгийн хэдэн хувьд хүрснийг зорилт, арга хэмжээ тус бүрээр тодорхойлох боломжгүй байна.
6. Хөтөлбөрийн хэрэгжилт хангалтгүй байгаа нь удирдлага зохион байгуулалтын хувьд тодорхой арга хэмжээ авч ажиллаагүй, шийдвэр гаргалт удаан, салбар хоорондын уялдаа хангагдаагүй, бэлтгэл ажил дуусаагүй, тодорхой үр дүн гарч эхлээгүй, авсан арга хэмжээ, үр дүнг бүрэн тайлагнаагүй, гүйцэтгэл дутуу зэргээс шалтгаалсан байна.
7. “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн хавсралтаар баталсан 16 шалгуур үзүүлэлтэд Бүсчилсэн хөгжлийн бодлоготой холбоотой шалгуур үзүүлэлтийг тусгаагүй, нийт зорилтот түвшинг 2025 оноор

тодорхойлж, тус хөтөлбөрийн 620 зорилтыг 16 шалгуур үзүүлэлтээр үнэлэн дүгнэхээр баталсан нь учир дутагдалтай байна.

8. “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний хүний хөгжлийн индекс, ядуурлын түвшин, дэлхийн инновацын индекс зэрэг шалгуур үзүүлэлтийн дагуу бодлогын зорилго, зорилт нь төлөвлөсөн зорилтот түвшинд хүрсэн эсэхийг хянан үзэхэд зарим үзүүлэлт нь 2-3 жил тутамд судалгааны үр дүнд суурилсан гардаг тул тус хөтөлбөрийн зарим үр дүнг тайлагнах, үнэлэх боломжгүй байна.

### САНАЛ

1. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3 дахь хэсэг, Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын 2 дахь заалтын 2-т тус тус заасны дагуу “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г баталж, хэрэгжилтийг зохион байгуулах;
2. Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд үр дүнд суурилсан төсөвлөлт, төлөвлөлтийг хэрэгжүүлэх, зорилт, арга хэмжээг агуулгын хувьд давхардуулан төлөвлөхгүй байхад анхаарах, хөтөлбөрийн 620 зорилтыг бүрэн хэрэгжүүлэхэд чиглэсэн үр дүнтэй арга хэмжээг төлөвлөн зохион байгуулах;
3. Бодлогын баримт бичигт тусган хэрэгжүүлэх зорилго, зорилт, шалгуур үзүүлэлтийн урьдчилсан судалгааг бүрэн хийж, зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээ, түүний үр дүнг үнэлэх суурь болон зорилтот түвшин, шалгуур үзүүлэлтийг оновчтой төлөвлөх, улмаар шалгуур үзүүлэлт, зорилтот түвшний дагуу иж бүрэн, үнэн зөв тайлагнаж, үнэлэх, үр дүнгүй байгаа арга хэмжээний шалтгаан нөхцөлийг тайлагнаж хэвших;
4. Тус хөтөлбөрийн зорилтыг хангахад шаардлагатай санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлж, ил тод байдлыг хангасан байх, хариуцлагатай байх зарчмыг баримталж, төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байдлаар зарцуулж, биелэлтийн явц, гүйцэтгэлд хяналт тавих;
5. Хөтөлбөрийн үр дүнг шалгуур үзүүлэлтийн дагуу Улсын Их Хуралд тайлагнах цаглаврын асуудлыг холбогдох байгууллагаас ирүүлэх статистик мэдээллийн эх сурвалж, мэдээлэл цуглуулах цаг хугацааны давтамжтай нийцүүлэн боловсронгуй болгох талаарх санал гаргах.
6. Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн явцад дотоод хяналтын тогтолцоог сайжруулж, үр дүнд чиглэсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг ирүүлэх зэрэг шаардлагатай байна.

---o0o---

**“МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР”-ИЙН  
2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАНГИЙН ҮР ДҮНГҮЙ /0-30 ХҮРТЭЛ ОНООГООР/ ҮНЭЛЭГДСЭН ЗОРИЛТ**

| Д/д                                   | Зорилт                                                                                                                                                                                                                                                                              | ЗГХХГ-ын<br>үнэлгээ,<br>хувь | УИХТГ-ын<br>үнэлгээ,<br>хувь |
|---------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------|------------------------------|
| <b>Нэг.Бүсчилсэн хөгжлийн бодлого</b> |                                                                                                                                                                                                                                                                                     |                              |                              |
| 1                                     | 1.1.2.5.Парк, Дамбадаржаа, Баянхошуу, Их наран дэд станц, 110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамуудыг барина.                                                                                                                                                                  | ХБ                           | 0                            |
| 2                                     | 1.1.2.11.Гэр хорооллын айл өрхүүдийн дулаан алдагдлыг бууруулж, эрчим хүчний хэмнэлт бий болгох дулаалгын төслийг хэрэгжүүлнэ.                                                                                                                                                      | ХБ                           | 0                            |
| 3                                     | 1.1.2.12.Багануур дүүргийн дулааны станцын зуух, дулаан дамжуулах сүлжээг өргөтгөн шинэчилж, засварлана.                                                                                                                                                                            | 0                            | 0                            |
| 4                                     | 1.4.1.7.Орон нутгийн ялгаатай татварын бодлого хэрэгжүүлнэ.                                                                                                                                                                                                                         | 0                            | 0                            |
| 5                                     | 1.2.2.4.Хөшигийн хөндийд шинээр бий болох сургалт, эрдэм шинжилгээний цогцолборыг түшиглэн "Кино, контент үйлдвэрлэлийн цогцолбор" байгуулна.                                                                                                                                       | 0                            | 0                            |
| 6                                     | 1.2.2.6.45000 тонн нарийн ногоо хураах өвлийн хүлэмжийн кластер бүхий Агросити эдийн засгийн тусгай бүсийн үйл ажиллагааг эхлүүлнэ.                                                                                                                                                 | 0                            | 0                            |
| 7                                     | 1.1.2.7.Багануур дүүрэгт 50 МВт буюу 200 МВт/цаг батарей хуримтлуурын станцыг барьж, оргил ачааллыг бууруулна.                                                                                                                                                                      | 100                          | 0                            |
| 8                                     | 1.3.1.2.Шинэ Хархорум хотын усны хэрэгцээг хангах бүтээн байгуулалтыг эхлүүлж, Орхон голд урсачын тохиргоо хийж, усан хангамжийг нэмэгдүүлэх төслүүдийг хэрэгжүүлнэ.                                                                                                                | 0                            | 0                            |
| 9                                     | 1.3.1.3.Орхон голын сав, Хангайн нурууны экосистемд түшиглэсэн рашаан сувилал, адал явдалт, түүх, соёлын аяллыг хөгжүүлж, археологийн нөөцөд тулгуурласан "Төв Азийн түүх, соёлын голомт" соёлын аялал жуулчлалын цогцолборыг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулна.    | 0                            | 0                            |
| 10                                    | 1.3.1.4.Бүс нутгийн онцлогт тохирсон мал үржүүлэг, үржлийн цөм сүрэг бий болгож, орон нутгийн хөгжлийн төвүүдэд хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа, бирж, тээвэр, логиستيкийн цогцолборыг кластераар хөгжүүлэх хувийн хэвшил, хоршоодыг тэргүүн ээлжид дэмжинэ. | ХБ                           | 0                            |
| 11                                    | 1.3.1.5.Байдрагийн усан цахилгаан станцын төслийг хэрэгжүүлнэ.                                                                                                                                                                                                                      | 0                            | 0                            |
| 12                                    | 1.3.3.2."Эрдэнэт үйлдвэр" төрийн өмчит үйлдвэрийн газрыг түшиглэсэн үйлдвэрлэл, технологийн паркийн хүрээнд зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэр байгуулна.                                                                                                               | 0                            | 0                            |
| 13                                    | 1.3.3.3.Эгийн голд эрчим хүчний нэгдсэн системийн горим тохируулгын үндсэн эх үүсвэр 310 МВт-ын хүчин чадалтай усан цахилгаан станц барина.                                                                                                                                         | 0                            | 0                            |
| 14                                    | 1.3.3.6.Улаанбаатар-Шар хөтөл-Эрдэнэт чиглэлийн авто замыг барина.                                                                                                                                                                                                                  | 30                           | 0                            |
| 15                                    | 1.3.2.2.Асгатын мөнгөний ордын нөөцийг тогтоож эргэлтэд оруулна.                                                                                                                                                                                                                    | 0                            | 0                            |
| 16                                    | 1.3.4.1."Тавантолгой" үйлдвэрлэл, технологийн паркийг түшиглэсэн Кокс-химийн цогцолбор барих ажлыг эхлүүлнэ.                                                                                                                                                                        | 0                            | 0                            |
| 17                                    | 1.3.4.3.Говийн бүсэд нар, салхины тус бүр 100 МВт хүртэл хүчин чадалтай цахилгаан станц барина.                                                                                                                                                                                     | 0                            | 0                            |
| 18                                    | 1.3.4.4.Тавантолгойн 450 МВт-ын хүчин чадалтай дулааны цахилгаан станц барина.                                                                                                                                                                                                      | 0                            | 0                            |

|                                    |                                                                                                                                                                                                                                                                                                     |    |   |
|------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----|---|
| 19                                 | 1.3.5.2.Дархан-Сэлэнгийн бүс нутагт металл боловсруулах болон металл бүтээгдэхүүний үйлдвэр, дагалдах үйлдвэр бүхий үйлдвэрлэл, технологийн парк байгуулна.                                                                                                                                         | 0  | 0 |
| 20                                 | 1.3.6.1.Зүүн бүсийг түүхэн аялал жуулчлалын төрөлжсөн бүс болгон хөгжүүлэх хүрээнд Бурхан халдун, Дэлүүн болдог, Буйр нуур, Халх гол, Алтан овоо, түүхэн аялал жуулчлалын газар нутгийг дэд бүтцээр холбох, усан боомт болон олон улсын 4С нисэх буудал байгуулна.                                  | 0  | 0 |
| 21                                 | 1.3.6.2.Зүүн бүсийг эрчимжсэн хөдөө аж ахуйн дэд бүсийн хувьд хөдөө аж ахуйн экспортыг дэмжих, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлнэ.                                                                                                                                            | ХБ | 0 |
| 22                                 | 1.4.1.3.Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа харьяа төсөвт байгууллага, төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчийн оролцоотой компани, түүний салбар нэгж болон салбарын нийт албан хаагчдын 10-аас доошгүй хувийг орон нутаг руу шилжүүлэх бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.           | ХБ | 0 |
| 23                                 | 1.4.1.4.Төвлөрлийг сааруулах хүрээнд Улаанбаатар хотоос орон нутагт шилжин үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүдийг дэмжих 1 хувийн хүүтэй 500 сая төгрөг хүртэлх зээл олгох бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.                                                                              | 0  | 0 |
| 24                                 | 1.4.1.5.Бүсийн хүний нөөцийн бодлого, нийгмийн баталгааг хангах төсөл, арга хэмжээ, түрээсийн орон сууцны хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.                                                                                                                                                                  | 0  | 0 |
| 25                                 | 1.4.1.7.Орон нутгийн ялгаатай татварын бодлого хэрэгжүүлнэ.                                                                                                                                                                                                                                         | 0  | 0 |
| 26                                 | 1.4.2.7.Аймгийн төвүүд болон томоохон хот, суурин газрын агаарын бохирдлыг бууруулна.                                                                                                                                                                                                               | 0  | 0 |
| <b>Хоёр.Хүний хөгжлийн бодлого</b> |                                                                                                                                                                                                                                                                                                     |    |   |
| 27                                 | 2.1.1.4.Гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төвийг бүх аймаг, дүүрэгт төр, хувийн хэвшлийн түншлэлээр ажиллуулж, гэр бүлд сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, гэр бүлийн гишүүдийн ёс зүйн хариуцлагыг дээшлүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.                                                                     | 30 | 0 |
| 28                                 | 2.1.1.16.Эрэгтэйчүүдийн зонхилон ажилладаг салбарт хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн урьдчилан сэргийлэх тогтолцоог бүрдүүлж, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчлөлийг бууруулна.                                                                                                  | 30 | 0 |
| 29                                 | 2.1.1.19.Өмчийн төрөл, хэлбэрээс үл хамаарч 50 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нийт ажлын байрныхаа 2 хувиас доошгүй орон тоонд ахмад настныг газрын доор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлтэйгөөс бусад ажлын байранд ажиллуулах хуулийн хэрэгжилтийг хангуулна. | 0  | 0 |
| 30                                 | 2.1.1.20.Ахмад настныг шинэ ур чадварт сургах, ажил, хөдөлмөр эрхлэх, орлогоо нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлнэ.                                                                                                                                                                                      | 0  | 0 |
| 31                                 | 2.1.1.24.Саадгүй байдал, хүртээмжийн тухай хуулийг батлуулж, хөгжлийн бэрхшээлтэй хүний тэгш, хүртээмжтэй дэд бүтцийн стандартыг албан байгууллага, бүх төрлийн орон сууц, худалдаа, үйлчилгээний байгууллагуудад мөрдүүлнэ.                                                                        | 30 | 0 |
| 32                                 | 2.1.1.25.Хөгжлийн бэрхшээлийн үйлдлийн чадамжийг тогтоох олон улсын аргачлалыг үе шаттайгаар нэвтрүүлж, салбар дундын нийгмийн үйлчилгээний нэр төрөл, хүртээмжийг нэмэгдүүлж, мэдээллийн тэгш байдлыг хангана.                                                                                     | 30 | 0 |
| 33                                 | 2.1.1.28.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөрлөх эрхийг хангаж, цахимаар, зайнаас, цагаар болон богино хугацааны хөдөлмөр эрхлэх, орлого олох боломжийг нэмэгдүүлнэ.                                                                                                                              | 70 | 0 |
| 34                                 | 2.1.1.32.Залуучуудад чиглэсэн спорт, соёл, урлагийн арга хэмжээнд соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээ худалдан авах эрхийн бичгийг ашиглан оролцох боломжийг бүрдүүлнэ.                                                                                                                                  | 0  | 0 |



|    |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                 |    |   |
|----|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----|---|
| 35 | 2.1.2.1.Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний нэгдсэн бодлогыг хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт, хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих эрх зүйн орчныг шинэчилж, салбар хоорондын хамтын ажиллагаа, бодлогын уялдааг хангана.                                                                                                                               | 30 | 0 |
| 36 | 2.1.2.11.Хөдөлмөр, нийгмийн гурван талт оролцоонд тулгуурлан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний тогтолцоог сайжруулна.                                                                                                                                                                                                                                            | 0  | 0 |
| 37 | 2.1.3.9.Төрөөс үзүүлж байгаа нийгмийн халамж, тусламж, үйлчилгээг зөвхөн зорилтот бүлэгт чиглүүлнэ.                                                                                                                                                                                                                                                                             | 0  | 0 |
| 38 | 2.1.4.1.Хүн амын бие бялдрын хөгжлийг хянах цахим технологи, өгөгдлийн системийг хөгжүүлж, нийтийн биеийн тамир, спортын орчны хүртээмжийг сайжруулна.                                                                                                                                                                                                                          | 0  | 0 |
| 39 | 2.1.4.2.Спортын сургалт, дасгалжуулалтыг сайжруулж, үндэсний шигшээ багийн нөөц тамирчдыг бэлтгэн, Дэлхийн аварга шалгаруулах тэмцээн болон олимпын наадамд гаргасан амжилтыг хадгалж, Азийн наадамд улсын дүнгээр эхний 15 байрт орох алхмыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.                                                                                                        | ХБ | 0 |
| 40 | 2.2.1.1.Дижитал шилжилт, технологийн өөрчлөлт, шинэчлэлийн сорилтыг даван туулах чадвартай, монголын түүх, хэл, соёл, үндэсний өв уламжлал, зан заншил, эх оронч хүмүүжлийг олгох боловсролын үндэсний хөтөлбөрийг хөгжүүлнэ.                                                                                                                                                   | 50 | 0 |
| 41 | 2.2.1.3.Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг их өгөгдөлд суурилан тооцоолж, шаардлагатай хүний нөөцийг бэлтгэнэ.                                                                                                                                                                                                                                                                    | 30 | 0 |
| 42 | 2.2.1.5.Хот, суурин газрын сургууль, цэцэрлэгийн бүлэг дүүргэлтийг стандартын түвшинд хүргэх "Нэг ээлж, цөөн хүүхэдтэй анги", "Гэрт ойр сургууль/цэцэрлэг-хамгийн сайн сургууль/цэцэрлэг" арга хэмжээг хэрэгжүүлнэ.                                                                                                                                                             | 30 | 0 |
| 43 | 2.2.2.7.Төрийн өмчийн их сургуулиудыг сургалтын их сургуулиас судалгааны их сургууль болгон хөгжүүлж, академик эрх чөлөөг ханган, инновацын экосистемийг бүрдүүлнэ.                                                                                                                                                                                                             | 30 | 0 |
| 44 | 2.2.2.11.Суралцагчдад олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хөтөлбөрөөр суралцах, дараагийн түвшний сургалтад кредит шилжүүлэн сурах, зарим мэргэжлийн дээд боловсролын сургалтын байгууллагыг 3 жилд төгсөх боломжийг олгох зорилгоор мэргэжлийн эрхтэй ахлах сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллеж, технологийн коллеж, их сургуулийг төрөлжүүлэн хөгжүүлнэ. | 30 | 0 |
| 45 | 2.2.2.12.Монгол Улсын их, дээд сургуулиуд дэлхийн шилдэг их сургуулиудтай хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, гадаадын нэр хүнд бүхий судлаач, эрдэмтдийг урьж ажиллуулах, оюутнуудыг гадаад улсад зуны сургалтад хамруулах бодлого хэрэгжүүлнэ.                                                                                                                   | 0  | 0 |
| 46 | 2.2.4.1.Боловсролын бодлого, санхүүжилт, хөрөнгө оруулалтын төлөвлөлтөд хүн ам, орон зай, их өгөгдөлд тулгуурласан хиймэл оюун ухааныг ашиглах замаар үр ашиг, оновчтой байдлыг сайжруулна.                                                                                                                                                                                     | 30 | 0 |
| 47 | 2.3.1.2.Хүн амын өвчлөл, нас баралтын тэргүүлэх шалтгааныг бууруулах, эрүүл мэндэд эрсдэл үүсгэж байгаа хүчин зүйлс, архи, тамхины хэрэглээг бууруулж, гар утсанд суурилсан стратегийн тусламжтайгаар иргэдийн эрүүл мэндийг хамгаалж, идэвхтэй хөдөлгөөн, эрүүл хооллолтыг дэмжинэ.                                                                                            | 0  | 0 |
| 48 | 2.3.2.2.Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ, эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх тогтолцоог бэхжүүлж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.                                                                                                                                                                                                                                          | 0  | 0 |
| 49 | 2.3.2.3.Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог боловсронгуй болгож, эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлж, зарцуулалтыг оновчтой болгон, иргэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авахад төлөх төлбөрийн хэмжээг бууруулна.                                                                                | 0  | 0 |
| 50 | 2.3.2.4.Маш цөөн хийгддэг, өндөр зардалтай тусламж, үйлчилгээг гадаад улсын эмнэлэгтэй хамтын гэрээ байгуулж, тусламж, үйлчилгээ үзүүлэх боломжийг бүрдүүлнэ.                                                                                                                                                                                                                   | 0  | 0 |

|                                    |                                                                                                                                                                                                                                                               |    |   |
|------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----|---|
| 51                                 | 2.3.2.5.Уламжлалт анагаах ухааныг орчин үеийн анагаах ухаантай хослуулан хөгжүүлж, уламжлалт эмийн үйлдвэрлэлийг олон улсын түвшинд хүргэн, экспортод гарах гарцыг нэмэгдүүлнэ.                                                                               | 0  | 0 |
| 52                                 | 2.3.2.7.Эрүүл мэндийн мэдээллийн нэгдсэн санг олон улсын стандартын дагуу бүрдүүлж, их өгөгдөл үүсгэнэ.                                                                                                                                                       | 0  | 0 |
| 53                                 | 2.3.2.8.Сэргээн засах тусламж, үйлчилгээг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлж, тусламж, үйлчилгээ шаардлагатай иргэдэд урт болон богино хугацаагаар, цогц байдлаар, нотолгоонд суурилсан тусламж, үйлчилгээг үзүүлж, чанар, аюулгүй байдлыг хангана.         | 0  | 0 |
| 54                                 | 2.3.3.1.Олон улсын зохистой дадал, стандартыг бүрэн нэвтрүүлж, эм, эмнэлгийн хэрэгслийн салбар дундын мэдээллийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, эмийн импортыг бүрэн цахимжуулна.                                                                               | 50 | 0 |
| 55                                 | 2.3.3.2.Эм, эмнэлгийн хэрэгслийн чанарыг хянах лабораторийг үндэсний түвшинд бэхжүүлэх, дотоодын эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрлэлийг олон улсын түвшинд хүргэж, экспортод гаргах боломжийг нэмэгдүүлнэ.                                                        | 30 | 0 |
| 56                                 | 2.3.4.2.Эмнэлгийн болон нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн бэлтгэж байгаа их, дээд сургуулийн сургалтын чанарыг олон улсын жишигт нийцүүлнэ. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагад ажиллах эмч, нийгмийн эрүүл мэндийн ажилтан, сувилагчийг түлхүү бэлтгэнэ. | 0  | 0 |
| 57                                 | 2.4.1.1.Үндэсний баялгийн сангаар дамжуулан иргэдийг орон сууцтай болоход дэмжлэг үзүүлж, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд орлогод нийцсэн орон сууцны нийлүүлэлтийг нэмэгдүүлж, орон сууцжуулалтыг эрчимжүүлнэ.                               | 0  | 0 |
| 58                                 | 2.4.1.4."Миний түрээсийн орон сууц" хөтөлбөрийг хэрэгжүүлж, ипотекийн хөнгөлөлттэй зээлийн бүтээгдэхүүнийг өмчлөх хэлбэрийн орон сууцны төслүүдийг хэрэгжүүлнэ.                                                                                               | 0  | 0 |
| 59                                 | 2.4.1.5."Хашаандаа сайхан амьдаръя" хөтөлбөрийг хэрэгжүүлж, эрчим хүчний хэмнэлттэй, байгаль орчинд ээлтэй амины орон сууц шинээр барих, засварлахад хөнгөлөлттэй зээл болон бусад дэмжлэг үзүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлнэ.                                 | 30 | 0 |
| 60                                 | 2.4.1.6.Эх үүсвэрээ бие даасан болон хэсэгчилсэн байдлаар шийдвэрлэсэн, байгаль орчинд ээлтэй, эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцны нийлүүлэлтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлого хэрэгжүүлж, дэмжлэг үзүүлнэ.                                            | 0  | 0 |
| 61                                 | 2.4.1.7.Гэр хорооллын иргэдэд эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууц барьсан тохиолдолд 30 сая төгрөгийн санхүүжилтийн дэмжлэг үзүүлнэ.                                                                                                                      | 30 | 0 |
| 62                                 | 2.4.2.1.Эрчим хүчний хэмнэлттэй, хүртээмжтэй, ногоон барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн санхүүжилт, төр, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлнэ.                                                                                                        | 0  | 0 |
| 63                                 | 2.4.2.2.Нийслэл, орон нутагт эрчим хүчний хэмнэлттэй, байгальд ээлтэй амины болон олон нийтийн зориулалттай орон сууцыг барих хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлнэ.                                                                                     | 0  | 0 |
| 64                                 | 2.4.2.8.Үйлдвэрлэлийн үйл ажиллагаан дахь төрийн оролцоог багасгах зорилгоор барилгын салбарын төрийн зарим чиг үүргийг мэргэжлийн холбоодод үе шаттайгаар шилжүүлж, дагалдах хариуцлагын тогтолцоог бэхжүүлнэ.                                               | 30 | 0 |
| 65                                 | 2.4.3.1.Барилга, орон сууцны ашиглалтын эрх зүйн орчныг шинэчилж, орон сууц ашиглалтын контор болон сууц өмчлөгчдийн холбооны үйл ажиллагааны эрх зүйн орчныг сайжруулна.                                                                                     | 0  | 0 |
| 66                                 | 2.4.3.2.Хүн амын ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээг хүртээмжтэй, тогтвортой, чанартай үзүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлнэ.                                                                                                                               | 30 | 0 |
| <b>Гурав.Эдийн засгийн бодлого</b> |                                                                                                                                                                                                                                                               |    |   |
| 67                                 | 3.1.3.2.Бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдэд таатай нөхцөлөөр санал болгох санхүүгийн бүтээгдэхүүнийг дэмжинэ.                                                                                                                                                | 70 | 0 |



|    |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                          |    |   |
|----|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----|---|
| 68 | 3.1.3.9.Хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийн байгууллагуудын системийн цогц шинэчлэлийг хэрэгжүүлж, олон улсын стандарт бүхий нэгдсэн шийдлийг зах зээлд нэвтрүүлнэ.                                                                                                                                                                                                        | 50 | 0 |
| 69 | 3.1.3.10.Хөрөнгийн зах зээлийн зохицуулалттай этгээдийн үйл ажиллагаанд шударга өрсөлдөөнийг бий болгож, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах тогтолцоог бүрдүүлнэ.                                                                                                                                                                                           | 0  | 0 |
| 70 | 3.2.1.3.Жижиг, дунд болон гарааны бизнес эрхлэгчдийн татварын дэмжлэгийг оновчтой болгож, татварын орчныг сайжруулна.                                                                                                                                                                                                                                                    | 50 | 0 |
| 71 | 3.2.1.5.Нийгмийн даатгалын тогтолцооны шинэчлэлийг үргэлжлүүлэн ажил олгогч, даатгуулагчид харилцан өгөөжтэй байх эрх зүйн зохицуулалтыг нэвтрүүлнэ.                                                                                                                                                                                                                     | 30 | 0 |
| 72 | 3.2.1.6.Ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээгээр тохирсон хөдөлмөрийн хөлсөнд нийгмийн даатгалын шимтгэл ногдуулахдаа уян хатан, хөнгөлөлттэй байх нөхцөлийг бүрдүүлнэ.                                                                                                                                                                                                 | 30 | 0 |
| 73 | 3.2.1.8.Хөдөө орон нутгаас Улаанбаатар хотыг чиглэсэн шилжилт хөдөлгөөнийг бууруулах, Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах зорилгоор бүсийн ялгаатай татварын тогтолцоог бүрдүүлнэ.                                                                                                                                                                                    | 30 | 0 |
| 74 | 3.2.2.1.Иргэн, хуулийн этгээдийн хувийн өмчийг хамгаалах эрх зүйн орчныг сайжруулна.                                                                                                                                                                                                                                                                                     | 0  | 0 |
| 75 | 3.2.2.8.Татварын өр хураах, хөрөнгө битүүмжлэх үйл ажиллагааг татвар төлөгчийн үйл ажиллагааны эрсдэлийн түвшнээс хамаарч уян хатан зохицуулдаг болж, хариуцлагатай татвар төлөгчийг дэмжинэ.                                                                                                                                                                            | 0  | 0 |
| 76 | 3.3.1.3.Монгол Улсын зэсийн ордуудыг түшиглэн зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэрийн байршлыг эцэслэн тогтоож, дэд бүтцийн нарийвчилсан техник, эдийн засгийн үндэслэлийн судалгааг хийж хэрэгжүүлнэ.                                                                                                                                                         | ХБ | 0 |
| 77 | 3.3.1.5.Түүхий эд, бүтээгдэхүүнийг анхан шатнаас гүн боловсруулах Кокс-химийн цогцолбор, Нүүрс-химийн цогцолбор, Зэс боловсруулах цогцолбор, Ган үйлдвэрлэлийн цогцолбор, Жоншны хүдэр боловсруулах цогцолбор, Барилгын материал үйлдвэрлэлийн цогцолбор зэрэг хүнд үйлдвэрүүдийг ашиглалтад оруулж, нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүн боловсруулна.                    | 0  | 0 |
| 78 | 3.3.1.9.Газрын тосны бүтээгдэхүүний 3-6 сарын хэрэглээний нөөц бүрдүүлэхэд шаардлагатай улсын нөөцийн шатахууны агуулахын барилга байгууламжийг ашиглалтад оруулна.                                                                                                                                                                                                      | 0  | 0 |
| 79 | 3.3.1.10.Алтны олборлолтыг нэмэгдүүлэх ба алт цэвэршүүлэх үйлдвэр барина.                                                                                                                                                                                                                                                                                                | ХБ | 0 |
| 80 | 3.3.2.4.Идэвхтэй ажиллагаатай боомтын тоог нэмэгдүүлж, ажлын цагийг уртасган, зарим боомтын тээвэрлэлтийг 24 цагийн горимд шилжүүлнэ.                                                                                                                                                                                                                                    | ХБ | 0 |
| 81 | 3.3.2.5.Тээврийн ерөнхий хууль, зам, тээврийн салбарын стратеги төлөвлөлтийг далайд гарцгүй орны онцлог болон бүсчилсэн хөгжлийн бодлоготой нийцүүлэн боловсруулж, үндэсний тээвэр, логистикийн нэгдсэн тогтолцоог хөгжүүлнэ.                                                                                                                                            | 0  | 0 |
| 82 | 3.3.2.7.Ханги-Номгон-Хөшигийн хөндий-Сүхбаатар чиглэлийн хоёр дахь төмөр зам, Арцсуурь-Нарийнсухайт-Шивээхүрэн, Чойбалсан-Бичигт чиглэлийн босоо тэнхлэгийн төмөр зам болон Улаанбаатар-Шинэ Хархорум хот чиглэлийн ачаа, зорчигч тээврийн 1 дүгээр зэрэглэлийн төмөр замыг барьж, төмөр замын сүлжээг өргөтгөж, 3200 км орчим төмөр замын бүтээн байгуулалтыг эхлүүлнэ. | 0  | 0 |
| 83 | 3.3.2.9.Улаанбаатар хотыг Шивээхүрэн боомттой холбосон авто замын төслийг хэрэгжүүлнэ.                                                                                                                                                                                                                                                                                   | 0  | 0 |
| 84 | 3.3.2.11.Орон нутгийн нисэх буудлуудыг 4С, 4D ангиллын шаардлагад нийцүүлэн өргөтгөх, хүчин чадлыг нэмэгдүүлэх ажлыг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлнэ.                                                                                                                                                                                                        | 0  | 0 |
| 85 | 3.3.2.15.Арцсуурь-Нарийнсухайт-Шивээхүрэн, Чойбалсан-Бичигт чиглэлийн төмөр замын төслийг үргэлжлүүлнэ.                                                                                                                                                                                                                                                                  | 0  | 0 |
| 86 | 3.3.2.21.Бичигт боомтыг холбох авто замын төслийг хэрэгжүүлнэ.                                                                                                                                                                                                                                                                                                           | 0  | 0 |

|     |                                                                                                                                                                                                                       |    |   |
|-----|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----|---|
| 87  | 3.3.2.22.Бүсүүдийн үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа, тээвэр логистикийн сүлжээг сайжруулж, улсын болон орон нутгийн чанартай авто зам, төмөр замын дэд бүтцийг бүтээн байгуулж, боомтуудын хүчин чадлыг нэмэгдүүлнэ.   | 30 | 0 |
| 88  | 3.3.2.24.Эрэнцав-Чойбалсан-Бичигт чиглэлийн босоо тэнхлэгийн төмөр замыг барина.                                                                                                                                      | 30 | 0 |
| 89  | 3.3.2.25.Өмнөговь аймгийн Гурвансайхан нисэх буудлыг 4D ангиллын болгон өргөтгөнө.                                                                                                                                    | 0  | 0 |
| 90  | 3.3.2.26.Ханх-Хатгал чиглэлийн авто замыг барина.                                                                                                                                                                     | 30 | 0 |
| 91  | 3.3.3.6.Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг хөгжүүлж, үйлдвэрлэлийн өртгийг бууруулна.                                                                                                                              | 0  | 0 |
| 92  | 3.3.3.7.Ураны нөөцийг түшиглэн атомын цахилгаан станц барих бодлого хэрэгжүүлж, суурь судалгааг хийнэ.                                                                                                                | 0  | 0 |
| 93  | 3.3.3.9.Нарны дулааны станц бүхий хэсэгчилсэн дулаан хангамжийн жишиг төслийг эхлүүлнэ.                                                                                                                               | 0  | 0 |
| 94  | 3.3.3.10.Өндөр түрэлтийн болон ус хуримтлуурт усан цахилгаан станцын төслүүдийн суурь судалгааны ажлыг хийнэ.                                                                                                         | 0  | 0 |
| 95  | 3.3.3.11.Шинээр барьж байгуулах нар, салхины эх үүсвэрийн төслүүдтэй уялдуулан 200 МВт-аас дээш хүчин чадалтай горим тохируулгын батарей хуримтлуурын системүүдийг барьж байгуулна.                                   | 0  | 0 |
| 96  | 3.3.3.12."10000 нарны дээвэр" хөтөлбөрийг төр, хувийн хэвшил, олон улсын байгууллагын шугамаар хэрэгжүүлнэ.                                                                                                           | 0  | 0 |
| 97  | 3.3.3.15.Эрчим хүчний аюулгүй байдал, чухал ашигт малтмалын салбарт Монгол Улсын байр суурь, оролцоо, хамтран ажиллах хоёр болон гурван талт механизмыг хөгжүүлнэ.                                                    | ХБ | 0 |
| 98  | 3.3.3.17.300 МВт хүртэлх салхины, 200 МВт хүртэлх нарны цахилгаан станцын төслүүдийг тархмал хэлбэрээр, хувийн хөрөнгө оруулалтаар үе шаттайгаар хэрэгжүүлнэ.                                                         | 0  | 0 |
| 99  | 3.3.3.18.Эрчим хүчний хэрэглээний хамгийн бага гүйцэтгэлийн стандарт, урамшууллын тогтолцоог нэвтрүүлнэ.                                                                                                              | 0  | 0 |
| 100 | 3.3.3.22.Эрчим хүчний найдвартай, аюулгүй, тогтвортой байдлыг хангаж, говийн бүсэд эхний ээлжид 300 МВт болон түүнээс дээш хүчин чадалтай цахилгаан станц барьж, ашиглалтад оруулан дотоодын хэрэгцээг бүрэн хангана. | 0  | 0 |
| 101 | 3.3.3.23.Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрт нар, салхины нөөцийн давхцалын бүсүүдийг түшиглэн 3 ГВт-ын нар, салхины сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрийг барьж байгуулах, экспортлох төслүүдийг дэмжинэ.                   | 0  | 0 |
| 102 | 3.3.3.24.Чойрт 100 МВт-ын салхины, 40 МВт-ын цэнэг хураагуурын төслийг хэрэгжүүлнэ.                                                                                                                                   | 50 | 0 |
| 103 | 3.3.3.25.Мандалговьд 200 МВт-ын нарны цахилгаан станц, 100 МВт-ын цэнэг хураагуурын төслийг хэрэгжүүлнэ.                                                                                                              | 0  | 0 |
| 104 | 3.3.3.26.Нарийнсухайтын 30 МВт-ын цахилгаан станцын төслийг хэрэгжүүлнэ.                                                                                                                                              | 0  | 0 |
| 105 | 3.3.3.28.Говийн бүсийн нар, салхины нөөцийг ашиглан, нар, салхины сэргээгдэх эрчим хүчний станцуудыг байгуулна.                                                                                                       | 0  | 0 |
| 106 | 3.3.3.30.Мандалговийн 2000 МВт-ын нар-салхины эрчим хүчний паркийн төслийг хэрэгжүүлнэ.                                                                                                                               | 0  | 0 |
| 107 | 3.3.3.32.Бөөрөлжүүт-Сэргэлэн чиглэлийн 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцыг барина.                                                                                                               | 0  | 0 |
| 108 | 3.3.3.34.Дархан ус хуримтлуурт усан цахилгаан станцын 100 МВт-ын төслийг хэрэгжүүлнэ.                                                                                                                                 | 0  | 0 |
| 109 | 3.3.3.35.Нэгдсэн сүлжээний горим тохируулах үүрэг бүхий 100 МВт хүртэл хүчин чадал бүхий усан цэнэгт цахилгаан станц барина.                                                                                          | 0  | 0 |
| 110 | 3.3.3.39.Сонгино-Дархан чиглэлийн 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамыг барьж, эрчим хүчний найдвартай ажиллагааг дээшлүүлнэ.                                                                                 | 0  | 0 |
| 111 | 3.3.3.41.Мөрөн хотод 50 МВт-аас доошгүй хүчин чадалтай дулааны цахилгаан станц байгуулах бэлтгэл ажлыг хангана.                                                                                                       | 0  | 0 |
| 112 | 3.3.3.42.Эрдэнэт хотын цахилгаан хангамжийг сайжруулахад шаардлагатай 35 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцыг барина.                                                                                 | 0  | 0 |

|     |                                                                                                                                                                                                                   |    |   |
|-----|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----|---|
| 113 | 3.3.4.1."Шинэ хоршоо хөдөлгөөн"-ийг үргэлжлүүлж, "Чинээлэг малчин" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.                                                                                                                       | 0  | 0 |
| 114 | 3.3.4.2."Хүнсний хангамж, аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөний хүрээнд гол нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотооддоо бүрэн хангаж, экспортод гаргах чиглэл баримтална.                               | 30 | 0 |
| 115 | 3.3.4.14."Цагаан алт" хөдөлгөөний хүрээнд малын гаралтай түүхий эдийн инновац шингэсэн эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг дэмжих бодлогыг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлнэ.                   | 50 | 0 |
| 116 | 3.3.4.16.Экспортын түүхий махны мал эмнэлэг, хорио цээрийн олон улсын шаардлагыг хангасан "Монгол мах" брэндийг хөгжүүлж, махны үнийг зах зээлийн зарчимд шилжүүлнэ.                                              | 30 | 0 |
| 117 | 3.3.4.18.Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний гарал үүслийн мөшгөлт, чанарын хяналтыг сайжруулж, биржээр дамжуулан экспортолно.                                                                                 | 0  | 0 |
| 118 | 3.3.4.22.Тариалангийн газрын хөрсний үржил шимийг хамгаалан сайжруулж, усалгаатай газар тариаланг нэмэгдүүлэх хөв, цөөрөм байгуулна.                                                                              | 0  | 0 |
| 119 | 3.3.4.23.Чанар, стандартын шаардлага хангасан бордооны үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.                                                                                                                                   | 0  | 0 |
| 120 | 3.3.4.27.Хүн амын эрүүл мэндийг хамгаалах зорилгоор хүнсний зориулалтын бус савны хэрэглээг бууруулна.                                                                                                            | 30 | 0 |
| 121 | 3.3.5.6.Аялал жуулчлалын бүс дэх хоршоо, нөхөрлөлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдааны сувгуудаар дэмжинэ.                                                                                                      | 0  | 0 |
| 122 | 3.3.5.7.Аялал жуулчлалын гол зам дагуу амрах өртөө, түр отоглох цэг, зорин очих газруудад ариун цэврийн байгууламж бүхий түр буудаллах цэг, үйлчилгээний цогцолбор байгуулна.                                     | 30 | 0 |
| 123 | 3.3.5.9.Бүсчилсэн хөгжлийн бодлогод тулгуурлан соёлын орон зай, хүртээмжийг нэмэгдүүлж, өөрийн орны иргэд, гадаадын жуулчдад үзүүлэх, борлуулах нөөцтэй болно.                                                    | 0  | 0 |
| 124 | 3.3.5.10.Говийн бүсийн Марс гарагтай төсөөтэй онцлогийг шинжлэх ухаан, инновац шингэсэн технологиор баяжуулж, байгаль орчинд ээлтэй, дөрвөн улирлын тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлнэ.                  | 0  | 0 |
| 125 | 3.3.5.11.Үндэсний болон олон улсын спортын арга хэмжээг зохион байгуулах, дэмжих замаар аялал жуулчлалыг хөгжүүлнэ.                                                                                               | 30 | 0 |
| 126 | 3.3.6.5.Соёлын биет болон биет бус өвийг эдийн засгийн эргэлтэд оруулах хатуу, зөөлөн дэд бүтэц, эрх зүйн орчныг бүрдүүлнэ.                                                                                       | 0  | 0 |
| 127 | 3.3.6.10.Үндэсний өв уламжлал, түүх, уран зохиол, нүүдлийн ахуй соёлыг шингээсэн хөтөлбөр, уран бүтээл, дижитал контент бүтээгчдийг дэмжиж, соёлын боловсролтой, эерэг хандлагатай, бүтээлч иргэдийг төлөвшүүлнэ. | 0  | 0 |
| 128 | 3.3.6.14.Соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээний түгээлтийн цахим шилжилтийн хүрээнд дэвшилтэт технологийг ашиглаж, "Цахим соёл II", "Соёлын эрхийн бичиг" системийг нэвтрүүлэх ажлыг үргэлжлүүлнэ.                     | 0  | 0 |
| 129 | 3.3.6.15.Соёлын бүтээгдэхүүн, контентыг аялал жуулчлалтай хослуулан хөгжүүлж, соёл, аялал жуулчлалын салбарыг 1 тэрбум ам.долларын орлого бүхий салбар болгон хөгжүүлнэ.                                          | 0  | 0 |
| 130 | 3.4.1.6.Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, экосистемийн тэнцвэртэй байдлыг хадгалахад хувь нэмэр оруулсан иргэн, аж ахуйн нэгжийг төрөөс урамшуулах тогтолцоог бүрдүүлнэ.                         | 0  | 0 |
| 131 | 3.4.1.7.Усны нөөцийн нэгдсэн менежментийг хэрэгжүүлж, усны үнэ цэн, үнэлэмжийг нэмэгдүүлэн ашиглалт, хэрэглээнд хэмнэлт, дахин ашиглалтыг дэмжинэ.                                                                | 30 | 0 |
| 132 | 3.4.2.9.Агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд хот, суурин газруудад яндангүй бүс байгуулж эрчим хүч, усны ухаалаг хэрэглээтэй амины орон сууцны хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ.                            | 30 | 0 |
| 133 | 3.4.3.11.Орхон-Онги, Хэрлэн-Тоонот ус дамжуулах хоолойг барина.                                                                                                                                                   | 50 | 0 |

| <b>Дөрөв.Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого</b> |                                                                                                                                                                                                                                                                                                              |    |   |
|--------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----|---|
| 134                                                    | 4.1.1.10.Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй хэрэгжүүлнэ.                                                                                                                                                                                                                                      | 0  | 0 |
| 135                                                    | 4.1.1.17.Прокурорын байгууллагын томилгоо, үйл ажиллагааны ил тод байдлыг хангах замаар хараат бус байдлыг нэмэгдүүлнэ.                                                                                                                                                                                      | 0  | 0 |
| 136                                                    | 4.1.2.2.Олон нийтийн радио, телевизийн бие даасан байдлыг хангах, хариуцлагатай, хараат бус, иргэдийг соён гэгээрүүлэх, хөгжүүлэхэд чиглэсэн нийтлэлийн бодлоготой болгох чиглэлээр эрх зүйн орчныг шинэчилнэ.                                                                                               | 30 | 0 |
| 137                                                    | 4.1.3.3.Нийгмийн зөвшилцөлд үндэслэн шийдвэр гаргах түвшинд иргэний нийгмийн байгууллага, мэргэжлийн холбоод, хувийн хэвшилтэй зөвлөлдөх, санал авах, гарсан шийдвэрийн биелэлтэд хяналт тавихад оролцдог оновчтой тогтолцоог бүрдүүлнэ.                                                                     | 30 | 0 |
| 138                                                    | 4.1.4.1.Төрийн үйл ажиллагаанд иргэдийн хяналт тавих тогтолцоог технологийн шийдлээр сайжруулж, шилэн ажиллагааг үргэлжлүүлж, төрийн нууцад хамаарахаас бусад бүх шийдвэр, тогтоол, гэрээ, хэлцэл, мэдээллийн санг олон нийтэд нээлттэй, ил тод болгоно.                                                     | 30 | 0 |
| 139                                                    | 4.2.1.3.Авлигатай тэмцэх "5Ш" ажиллагааг үргэлжлүүлж, авлига, ашиг сонирхлын зөрчлийг мэдээлэх тогтолцоог хялбаршуулах, энэ төрлийн гэмт хэргийн эсрэг шүгэл үлээгчийг хамгаалах, дэмжих хууль, эрх зүйн орчныг бүрдүүлнэ.                                                                                   | 0  | 0 |
| 140                                                    | 4.2.1.4.Улс төрийн хүрээнд авлигатай тэмцэх хүсэл зориг, хүчин чармайлт, манлайлал, ил тод байдлыг төгөлдөржүүлж, улс төрийн намын санхүүжилтийн талаарх эрх зүйн зохицуулалтыг сайжруулна.                                                                                                                  | ХБ | 0 |
| 141                                                    | 4.2.1.8.Улс дамнасан, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний чадавхыг дээшлүүлж, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх мөрдөх албыг байгуулж мэргэшүүлж, гадаад хамтын ажиллагааг сайжруулна.                                                                                                         | 0  | 0 |
| 142                                                    | 4.2.1.11.Ялын бодлогыг нийгмийн хөгжлийн чиг хандлагатай уялдуулж, ялтныг хөдөлмөрлөх нөхцөлөөр хангаж, гэмт хэргийн улмаас бусдад учруулсан хохирол барагдуулалтыг нэмэгдүүлэх, ялтныг нийгэмшүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.                                                                           | 0  | 0 |
| 143                                                    | 4.2.1.14.Гэрч, хохирогчийг хамгаалах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэргийг мөрдөн шалгах алба шинээр байгуулж, хохирогчийн эрхийг хангах, хохирол барагдуулах үйл ажиллагааг шинэ шатанд гаргана.                                                                                           | 0  | 0 |
| 144                                                    | 4.2.1.15.Тагнуулын үйл ажиллагаа болон нууц мөрдөн шалгах ажиллагааны зааг ялгааг тодорхой болгож, эрх зүйн орчныг тус тусын хуулиар зохицуулна.                                                                                                                                                             | ХБ | 0 |
| 145                                                    | 4.2.1.16.Иргэдийг чадавхжуулах, гамшиг, аюулаас сэргийлэх сургалт, авран хамгаалах зохион байгуулалтыг дэмжин ажиллах, орон нутгийн хамгаалалт, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, хууль сахиулах болон үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхад дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий үндэсний тогтолцоог бий болгоно. | 30 | 0 |
| 146                                                    | 4.2.2.4.Төрийн тогтолцооны цахим дэд бүтцийг хөгжүүлж, шийдвэр гаргах үйл явцыг хурдан, ил тод, нээлттэй болгоно.                                                                                                                                                                                            | 30 | 0 |
| 147                                                    | 4.2.3.2.Хяналт шалгалтын тогтолцоог сайжруулж, олон улсын үнэлгээний цогц систем /DME-Design, Monitoring and Evaluation/-ийг хөгжүүлж, бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийн үнэлгээг боловсронгуй болгоно.                                                                                                | 30 | 0 |
| 148                                                    | 4.2.3.3.Төрийн үйлчилгээнд процессын дахин инженерчлэл хийх ажлыг үргэлжлүүлэн төрд байгаа мэдээллийг иргэн, аж ахуйн нэгжээс шаарддаг байдлыг бүрэн халах, иргэн, хуулийн этгээд нэг удаа бүртгүүлээд төрийн цахим үйлчилгээг шуурхай, чирэгдэлгүй авах нөхцөлийг бүрдүүлнэ.                                | 30 | 0 |
| 149                                                    | 4.2.3.7.Төрийн албаны хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх, хөгжүүлэх тогтолцоог сайжруулж, Төрийн албанд 5-аас дээш жил үр бүтээлтэй ажиллаж, сүүлийн 3 жилд нь "маш сайн"                                                                                                   | 0  | 0 |

|     |                                                                                                                                                                                                                                                                                                 |    |   |
|-----|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----|---|
|     | үнэлэгдсэн төрийн албан хаагчийг "1+2" буюу гадаадад хэлний болон ахисан түвшний сургалтад хамруулах бодлого баримтална.                                                                                                                                                                        |    |   |
| 150 | 4.2.3.8.Төрийн албаны сургалтын байгууллагын хөтөлбөрийг төрийн албаны шинэчлэлд нийцүүлж, сургалтын байгууллагын чадавхыг бэхжүүлнэ.                                                                                                                                                           | 30 | 0 |
| 151 | 4.2.3.10.Төрийн албан хаагчдын цахим мэдээллийг өөрт нь нээлттэй болгох замаар төрийн албан хаагчийн иж бүрэн цахим платформыг хөгжүүлж, мэдээллийн үнэн зөв, бүрэн гүйцэд байдлыг сайжруулна.                                                                                                  | 0  | 0 |
| 152 | 4.2.3.11.Хууль сахиулагчдын мэргэшил, нийгэм, эдийн засгийн баталгааг сайжруулж, хууль сахиулагч болон хууль сахиулах албаны эрх зүйн байдлыг тодорхойлсон хууль, эрх зүйн орчныг бий болгоно.                                                                                                  | 0  | 0 |
| 153 | 4.2.3.13.Төрийн албаны ёс зүйн индекс, ёс зүйн дэд бүтцийг олон улсын туршлагад суурилан хэрэгжүүлнэ.                                                                                                                                                                                           | 0  | 0 |
| 154 | 4.2.4.1.Хотын ерөнхий болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг оршин суугч, аж ахуйн нэгжийн саналыг харгалзан боловсруулан батлуулж, үүнтэй уялдуулан төсвийн болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт, зарцуулалтын бодлогыг хэрэгжүүлнэ.                                            | 0  | 0 |
| 155 | 4.3.1.4.Төрөөс иргэн, бизнест үзүүлж байгаа үйлчилгээнүүдэд процессын шинжилгээ хийж бүрэн цахимжуулах, хиймэл оюун ухааныг ашиглах, автоматжуулах боломжийг тодорхойлж, үйлчилгээ авах хугацаа болон үе шатыг 2 дахин бууруулна.                                                               | 30 | 0 |
| 156 | 4.3.2.2.Мэдээллийн технологи, харилцаа холбооны хамрах хүрээг өргөжүүлж, орон нутагт өндөр хурдны интернэтийн сүлжээг хүртээмжтэй болгож, интернэтийн орон нутгийн тарифыг эрс бууруулж, Улаанбаатар хотын тарифтай ойртуулж, төрийн үйлчилгээг цаг алдалгүй, шуурхай авах боломжийг бүрдүүлнэ. | 30 | 0 |
| 157 | 4.3.2.7.Олон улсын цахим төлбөрийн системүүдийг нэвтрүүлж, төлбөр тооцоог саадгүй хүлээн авах боломжийг бүрдүүлэн цахим худалдааг дэмжинэ.                                                                                                                                                      | 50 | 0 |
| 158 | 4.3.3.4.Хувь хүний мэдээллийн аюулгүй байдал, цахим болон тоон гарын үсэг, мэдээллийн сангийн аюулгүй байдлыг хангах цахим засаглалын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.                                                                                                              | 30 | 0 |
| 159 | 4.4.1.1.Монгол хүний бахархал, өв соёл, нүүдлийн соёлыг дэмжих үндэсний соёлын үнэт зүйлд суурилсан нийгмийн соён гэгээрлийн бодлого баримталж, үндэсний нэгдмэл үнэт зүйлийг бэхжүүлнэ.                                                                                                        | 0  | 0 |
| 160 | 4.4.1.4.Эрүүл чийрэг, эх оронч, хариуцлагатай иргэнийг төлөвшүүлэх “Эх оронч монгол” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.                                                                                                                                                                                   | 0  | 0 |
| 161 | 4.4.2.7.Монгол Улсын түүх, соёлд холбогдох гадаад улсад хадгалагдаж байгаа баримтыг эх нутагт нь байршуулж, үндэсний санах ой болох архивын баримтын хадгалалт, хамгаалалтын нөхцөлийг сайжруулж, архивын баримтыг эдийн засгийн эргэлтэд оруулна.                                              | 30 | 0 |
| 162 | 4.4.2.9.Олон улсын сансар судлалын хамтын судалгааны уулзвар цэг байх, хамтын ажиллагааны таатай орчин бүрдүүлэх бодлого баримтална.                                                                                                                                                            | 0  | 0 |
| 163 | 4.4.2.16.Бүс нутгийн эдийн засгийн интеграцид нэгдэж, экспортыг нэмэгдүүлэх, төрөлжүүлэх, гадаад худалдаанд тулгарч байгаа хүндрэлүүдийг багасгах, хөнгөвчлөх бодлогыг үргэлжлүүлнэ.                                                                                                            | 30 | 0 |
| 164 | 4.4.3.2.“Технологийн дэвшил-Зэвсэг техникийн шинэчлэл” зорилтод нийцүүлэн Зэвсэгт хүчний зэвсэг, техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах төрийн бодлогыг хэрэгжүүлж, орчин үеийн дэвшилтэт техник, хэрэгслээр хангана.                                                                           | 30 | 0 |
| 165 | 4.4.3.10.Батлан хамгаалах материаллаг нөөцийг бүрдүүлэх, түүний хадгалалт, хамгаалалтыг сайжруулах шат дараатай арга хэмжээг хэрэгжүүлнэ.                                                                                                                                                       | 0  | 0 |
| 166 | 4.4.5.2.Эрсдэлийг урьдчилан илрүүлэх, үнэлэх, эрэмбэлэх, хариу арга хэмжээ авах, хэрэгжилтэд үнэлгээ хийх системийг хөгжүүлж, эрсдэлийн удирдлагын шинэчлэлийг эхлүүлнэ.                                                                                                                        | 30 | 0 |

---o0o---